

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр, Даваа гараг**

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-9

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 10-57

- 
1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 10-48
2. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 48-57

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Нийгмийн бодлогын байнгын хорооны 12 дугаар сарын 09-ний өдөр  
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 61.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Б.Баясгалан, Ц.Мөнхтуяа;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа, М.Ганхүлэг, Б.Түвшин.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуралдаанд оролцов.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цогтбаатар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, Тусламж, үйлчилгээ, чанар төлбөрийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, Гэрээлэлт, худалдан авах ажиллагааны газрын дарга Х.Ганцэцэг, Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Б.Оюунцэцэг, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Б.Мажигсүрэн, Ё.Энхсайхан, мөн газрын

Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ц.Идэрбат, М.Нарантуяа-Нара, С.Эрдэнэбат, Б.Бейсен, О.Саранчулуун, Д.Үүрийнтуяа, А.Ариунзаяа, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир нар хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энхнасан:** 1.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтын XXI.1.8 дахь заалтын “Налайх, Дулааны шинэ эх үүсвэр 216 МВт-ын эхний ээлжийн ажил /Улаанбаатар, Налайх дүүрэг/, төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,906.5 тэрбум төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Нийслэлийн Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилга” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Байнгын хорооны дарга Л.Энхнасан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 10  
Бүгд: 16  
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, М.Сарнай нарын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан:** 2.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзоригийн гаргасан, Төрийн албан хаагчийн цалинг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлж, холбогдох санхүүжилтийг хэмнэсэн 219.0 тэрбум төгрөгийг Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зарцуулах. Үүнд:

1/Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл

2/Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл  
3/Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл  
4/Улаанбаатар хотын төсвийн дулаан хангамжийн төсөл  
5/Улаанбаатар хотын ногоон орон сууц төсөл гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг саналаа тайлбарлав.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 16  
Бүгд: 16  
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

**Л.Энхнасан:** 3.Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоолны материал худалдаж авах зардлыг 31.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан НҮБ-ын “Цөлжилттэй тэмцэх тухай” суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын төхөөрөмж, барилга байгууламжийн санхүүжилтийг 31,4 тэрбум төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлж, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 12  
Бүгд: 16  
25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.1 дэх дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлсөн иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, 2025 оны зорилтот түвшин “14564” гэснийг “15154” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 10  
Бүгд: 16  
37.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 31.4.4.2 дахь дэд заалтын Шалгуур үзүүлэлт “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэн” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо” гэж, суурь түвшин “35281” гэснийг “172967” гэж, 2025 оны зорилтот түвшин “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.3.2 дахь дэд заалтын суурь түвшин “36” гэснийг “16.7” гэж, 2025 оны зорилтот түвшин “40” гэснийг “20” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1 дүгээр хавсралтын 31.5.1.1 дэх дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “5” гэснийг “3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 16 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1-р хавсралтын 31.5.2.1 дэх дэд заалтын суурь түвшин “9386” гэснийг “1126” гэж, 2025 оны зорилтот түвшин “10500” гэснийг “1200” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 1-р хавсралтын 31.5.1.2 дахь дэд заалтын 2025 оны зорилтот түвшин “16” гэснийг “12” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун, М.Нарантуяа-Нара, Б.Бейсен, М.Сарнай нарын гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний 2025 онд дуусгахаас бусад хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх дүнг 40 тэрбум төгрөгөөр бууруулж, Эрүүл мэндийн даатгалын сан болон Нийгмийн даатгалын санд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдсэнтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхээр тусгах зохицуулалт хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлж, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Л.Энхнасан дээрх саналын эх үүсвэр тодорхойгүй тул санал хураалт явуулах боломжгүй талаар хэлж, санал хураалтыг явуулаагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын

газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Цогтбаатар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Энхболд, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ихтамир, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч М.Нармандах, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Батчимэг, Тусламж, үйлчилгээ, чанар төлбөрийн хяналтын газрын дарга Г.Ариунсайхан, Гэрээлэлт, худалдан авах ажиллагааны газрын дарга Х.Ганцэцэг, Дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээний газрын дарга Б.Оюунцэцэг, Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Гантөмөр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх М.Отгон, Б.Мажигсүрэн, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хороодын ажлын албаны Нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

***Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:***

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар үг хэлэв.

*Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа үг хэлэв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг “Энэ хуулийн батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө” гэснийг “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.*

Төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн тавьсан асуултад Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж хариулж, тайлбар хийв.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдүүлж байгаа барилга байгууламжийн төсөвт өртгийг



Барилга хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төвийн эрх бүхий төсөвчдийн хийж байгаа үйл ажиллагаа, нэмэгдсэн төсөвт өртгийн магадлалд дахин шалгалт хийж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

**“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

*“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, О.Саранчулуун, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 8  
Бүгд: 16  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 7  
Бүгд: 16  
56.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Горимын санал дэмжигдсэн тул 1.6.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Л.Энхнасан:** Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, О.Саранчулуун, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн нарын гаргасан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын харьяа шинээр баригдах хөрөнгө батлагдаагүй нэн шаардлагатай зарим газар, байгууллагуудад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 6  
Бүгд: 16  
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 54 минут үргэлжилж, 21 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 76.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 12 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
12 цаг 18 минут.

### НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энхнасан:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Даваасамбуу Ганмаа, Мөнхтөрийн Нарантуяа-Нара, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Буланы Бейсен, Сархадын Зулпхар, Отгоны Саранчулуун, Хөххүүгийн Болормаа, Цагаанхүүгийн Идэрбат, Мягмардашийн Сарнай, Сүхбаатарын Эрдэнэбат нар оролцож байна. Өнөөдөр чөлөө авсан гишүүд Баясгалан гишүүн, Мөнхтуяа гишүүн чөлөө авсан байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэж ирж, Байнгын хорооны ирц 61,9 хувьтай бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд. Засгийн газрын 2024 оны 12 сарын 04-ний өдрийн өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

2 дугаарт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолуудын төсөл. Засгийн газар 2024 оны 12 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё.

**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг эхлүүлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Жавхлан сайд орж ирж байна. Бусад гишүүдийг танилцуулж байна.

Наранчимэг орж ирсэн үү? Үндэсний аудитын газар Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Энхтуяа Үндэсний аудитын газар Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Сангийн яамнаас Жавхлан сайд орж ирж байгаа. Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Тэлмүүн Сангийн яамны Татвар бодлогын газрын дарга, Золбоо Сангийн яамны Санхүү, төлөвлөлтийн судалгааны газрын дарга, Сонор Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Отгонцэцэг Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Цогтбаатар Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ганцэцэг НДЕГ-ын даргын албыг үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын дарга, Энхболд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Ихтамир Хүүхэд гэр бүл, хөгжлийн хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бауыржан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Нармандах Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч, Батчимэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Очирбат Эрүүл мэндийн Төрийн нарийн бичгийн дарга, Аюурсайхан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Тусламж үйлчилгээ, чанар төлбөрийн хяналтын газрын дарга, Ганцэцэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Гэрээлэлт худалдан авалт ажиллагааны газрын дарга, Оюунцэцэг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, Гантөмөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Батдорж Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Залуучуудын хөгжлийн бодлого, хэрэгжилтийг зохицуулсан газрын дарга.

Эдгээр ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын, Жавхлан сайд маань орж ирсэн үү? Жавхлан сайд орж байна. Жавхлан сайдыг түр хүлээе. Ёс зүйн байнгын хорооноос орж ирнэ.

Сангийн яамаар танилцуулах хүн байна уу? Танилцуулгыг бэлэн байгаа юм чинь. Сайд ороод ирлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн яам, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. 5 дугаар микрофоныг.

**Б.Жавхлан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хэлэлцэн баталсан. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч алдагдалгүй төсөв батлах тухай чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг дахин боловсруулж, өргөн барилаа.

Төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчмыг баримталлаа.

1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийг даатгалын сангаас санхүүжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-ноос төсвийг нь хянаж, жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн байгууллагуудын болон ХЭҮК зэрэг байгууллагуудын урсгал зардлыг тус тус хэвээр нь хадгаллаа.

2. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна.

Салбар харгалзахгүйгээр бүх төсөв, байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 10 хувь буурууллаа.

Соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагын үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал хөдөлмөрийн зардлыг 100 хувь буурууллаа.

В.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолтын болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, ХЗДХ-ийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж техник, хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулъя.

Дээр дурдсан 50-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга

хэмжээ боловсруулан, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувь хувиар тус тус буурууллаа

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгая.

4. Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж хойшлуулна.

Зарим их их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлуулъя.

6. Гадаад зээлийн ашиглалтыг бууруулж, хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлуулъя.

ХСҮТ-2 хөрөнгө оруулалтыг нэмж тус тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394,8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн мөн 33 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35 хувьд хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3,3 хувьтай эерэг байхаар байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын 2025 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Эдгээр хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа.

Дараачийн танилцуулгыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг танилцуулна. Ажлын хэсгийн. Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Цэдэнжав Танилцуулна. Микрофон ажлын хэсгийн 3 дугаар микрофон.

**3.Цэдэнжав:** Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэж, аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь ач холбогдолтой болжээ.

Иймд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 11 дүгээр сарын хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн хүлээж авч, алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьжээ.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилгод нийлсэн эсэхийг хянаж дүгнэхэд чиглэсэн болно.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 69,2 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн сайд 7,9 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сан 6 их наяд 928,7 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сан 2 их наяд 515,6 тэрбум төгрөг буюу 9 их наяд 521,4 тэрбум төгрөгөөр төлөвлөж, өмнөхөөс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 6 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сан 15,1 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сан 10 тэрбум төгрөгөөр, нийт 31,1 тэрбум төгрөгөөр тус тус бууруулан төлөвлөсөн байна.

Төсвийн зардлыг 2025 оны төсөлд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 4 их наяд 496,9 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн сайд 1 их наяд 820,9 тэрбум төгрөг, Нийгмийн даатгалын сангийн төсөв 5 их наяд 815,5 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сан 2 их наяд 216,3 тэрбум төгрөг буюу нийт 14 их наяд 349,6 тэрбум төгрөгөөр төлөвлөж, өмнөхөөс нийт 139,1 тэрбум төгрөгөөр буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцыг 105,2 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн сайдын багцыг 33,9 тэрбум төгрөгөөр тус тус зардлыг бууруулжээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл, урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал, улсын хөгжлийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг анхаарах нь зүйтэй байна. Үүнд:

1 дүгээрт, гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж, нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай,

2 дугаарт, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд төсөвт өөрчлөлт орох бүрд нэмж өөрчлөлт орж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3.Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсөвт өртгийг үндэслэлтэй тооцож, үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4.Төсвийн урсгал зардлыг хумьж, зарим хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр, үйл ажиллагааг зогсоогоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулах, тоо хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5.Төрийн үйлчилгээг илүү цомхон, бүтэц ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль, эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газрын тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гарсан хууль тогтоомжтой нийцэхгүй байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Энхнасан:** Баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргэсэн болно.

Хууль санаачлагчдаас болон Байнгын хорооны ерөнхий эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Нэрээ өгнө үү? Ариунзаяа гишүүнээр тасаллаа.

Орохгүй байна уу? Гараа өргөх үү? Ороогүй хүмүүс. Идэрбат гишүүн, Бейсен гишүүн, Эрдэнэбат гишүүн Нарантуяа-Нара гишүүн, Болормаа гишүүн. Болормаа гишүүнээр тасаллаа. Чинбүрэн гишүүн асуултаа асууна.

**Ж.Чинбүрэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Би нэг 2 зүйлийг л яримаар байгаа юм.

Сангийн яам байгаа учраас Жавхлан сайдад би өмнө нь ярьж байсан. Энэ төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална гээд 27.6-д заасан байгаа. 27.6.1-д шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ гээд. Тэгэхээр энэтэй холбоотойгоор 24 онд тавьсан 2 арга хэмжээ буюу 1 нь БЗД-ийн эмнэлэг худалдан авах үйл ажиллагаа, нөгөөдөх нь БЗД-т мөн ялгаагүй цэцэрлэг худалдан авах үйл ажиллагаа, 2 ажил байгаа. Энэ 2 бол тендер нь зарлагдаад, тэгээд



жишээлбэл, эмнэлгийн худалдан авах үйл ажиллагаа 2 удаа тендер нь зарлагдаад, амжилтгүй болчихсон. Тендерийн үйл ажиллагаа үргэлжилж байгаа юм байна.

Нөгөөдөх нь болохоор цэцэрлэг худалдан авах үйл ажиллагаа бас тендер нь зарлагдчихсан ийм байж байгаа. Тэгэхээр энэ 2 үйл ажиллагааг үргэлжлүүлэх тал дээр яах ёстой вэ? Та зөвлөгөө өгнө үү? Тэгэхээр манайд, БЗД-т ийм 2 чухал ажлын 25 оны төсөвт суугдаагүй хасагдчихаад, өмнө нь асуухад бол нөгөө 24 ондоо амжиж хийгээгүй учраас ингээд хассан гэсэн ийм байгаа даа. Тэгэхдээ тендер нь зарлагдсан, тендерийн үйл ажиллагаа явагдаж байгаа юм байна. Энэ дээр Сангийн яам хариулт өгөөч.

Дараагийн 3 дахь нэг хэлэх гэсэн зүйл бол 24 онд Хавдар-2 төсөл дээр 5 тэрбум төгрөг тавьсан байгаа. Тэгэхээр Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан та энэ 24 онд байгаа 5 тэрбум төгрөг дотор одоо бид Хавдар-2 төслийн газрын асуудал бол эцэслэн шийдэгдлээ. СХД-ийн 34 дүгээр хороонд 12 га газар СХД-ийн Засаг даргаас газрыг нь, гэрчилгээг нь ХСҮТ дээр гаргаад өгчихсөн. Тийм учраас энэ төсөвт мөнгө хүрэлцэхгүй, хийх ажил их байгаа. Тийм учраас 24 онд байгаа энэ 5 тэрбум төгрөгөө амжиж ашиглах, үүнийгээ хураалгачихгүйгээр энэ төсөл, арга хэмжээг эхлүүлэх энэ ажил дээр анхаараарай.

Би Сангийн яамныхантай уулзаж ярилцсан. Төрийн нарийн бичигтэй нь ч ярьсан. Энэ 5 тэрбумтай холбоотой Хавдар судлал төсөл 2 гэдэг арга хэмжээ учраас энэ төслийн арга хэмжээ, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хийхэд бол ямар нэгэн зөрчилдөх зүйл байхгүй гэж тайлбар хэлсэн. Тийм учраас манай ЭМЯ-ныхан энэ дээр анхаараарай. Аль болохоор л хурдан ажлуудаа эхлүүлэх тал дээр онцгой идэвх чармайлттай ажиллахгүй бол харж байгаа биз, төсөв дээр ямар их мөнгө төсөв дутаж байна.

Тэгээд мөнгө байхад хийж чадахгүй байж байгаад алдчих юм бол хэдүүлээ харин ичгүүртэй байдалд орох вий. Ингээд асуултад хариулт авъя.

**Л.Энхнасан:** Жавхлан сайд, 5 дугаар микрофоныг нээнэ үү.

**Б.Жавхлан:** Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Бид 09 сарын 01-нд 25 оны төсөв өргөн барихад мөн л яг ийм зарчим баримталсан. Өөрөөр хэлбэл яг тухайн үед энэ жил эхлэх ёстой байсан боловч гэрээ битгий хэл, тендерээ ч зарлаж амжаагүй байсан нэлээн олон төслүүд байгаа. Түүн дотор энэ 2 төсөл орсон байгаа. Өөрөөр хэлбэл бэлтгэл ажил дутуу хангагдсанаас болоод ингээд тендер зарлах, гэрээ байгуулах ажил нь ингээд тухайн жилдээ ингээд хойшлогдоод, хоцроод, тэгээд дараа жилүүдийнхээ төсвийн санхүүжилтэд ингээд улам л нөгөө цасан нуранги шиг проблем нь нэмэгдээд байдаг юм.

Тийм учраас бүгдэд нь ижил зарчим баримтлаад, юу вэ гэхээр төсөл бол хасагдахгүй, төсөл бол хасагдахгүй. Энэ жил амжаад л яаж ийж байгаад л тендерээ ядаж зарлаад, гэрээгээ байгуулчих хэрэгтэй. Харин 25 оны санхүүжих дүн бол хасагдана. Ингээд 26 оных дээрээс үргэлжлэх ийм боломж нээхийн тулд гэрээгээ л хийх ёстой, тендерээ л хийх ёстой байгаа. Үнэхээр яг онцын шаардлагатай гэж үзвэл Засгийн газар дээрээс эдгээр төслүүд дээр салбар салбарын саналыг үндэслэж эрэмбэлээд, 24 онд санхүүжих ёстой байсан дүнгээ хэрвээ үлдэгдэлтэй гарах юм бол түүнийг нь 25 онд үргэлжлүүлэх зорилгоор

дундын дансанд бол хадгалах хууль зүйн боломж бол байгаа. Гагцхүү салбарын санал үндэслэлтэй байх нь л чухал юм. Тийм. Тэгэхээр энэ 2 төсөл дээр бол хоёуланд нь ийм юм байгаа.

Цэцэрлэгийн хувьд бол бүр байрлалаа солих, хороог солигдох эд нар гээд сүүлд нэг тийм нэмэлт мэдээлэл ирсэн байгаа. Энэ дээр манай яамнууд анхаарна биз.

Хавдар 2 дугаар эмнэлгийн хувьд ирэх жил ингээд ямар ч байсан төсөл маань өөрөө гараанаас гарлаа гэсэн үг. Газар болон бусад бэлтгэл ажлаа бол хангагдсан гэж үзэж байгаа. Энэ жилийн төсвөө ч гэсэн ер нь аль болох гүйцэтгэлийг нь гаргаад, энэ жилд тавигдсан мөнгөө авчих хэрэгтэй. Тэгэх юм бол нэлээн ажлууд явчихна. Ирэх жилийн хувьд худалдан авах ажиллагаа дээр зураг төслийн ажил амжилт юу, худалдан авах ажиллагаа нь амжилттай явагдаад, компани шалгараад гэрээ нь байгуулагдсан учраас яг барилгын хэсгийн ажил бол цаашаа дараа дараагийн онуудад бол ингээд үргэлжлээд явна гэж төлөвлөж байгаа.

**Л.Энхнасан:** Идэрбат гишүүн асуултаа асууна уу?

**Ц.Идэрбат:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. 2025 оны төсвийн хэлэлцүүлгүүд явагдаж байна. Тэгээд 2024 оны 11 сарын 08-нд өргөн барьж батлагдаад, Ерөнхийлөгчийн хориг тавигдсан төсвөөс ялангуяа эрүүл мэндийн салбар дээр 36,8 тэрбум төгрөгийн буурсан ийм дүнтэй орж ирж байгаа юм байна. Тэгэхээр энэ бууралт юунаас хасагдсан юм бэ гэдэг 1 дүгээр асуулт байна.

2 дугаарт, Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн нөхцөл байдал бол энэ сангаас цалинждаг, энэ сангаас санхүүждэг олон байгууллагуудад нэлээдгүй хүндрэлүүд учруулаад байгаа юм байна. Ялангуяа жилийн эцэс болж байгаатай холбогдуулаад татвар, нийгмийн даатгалтай холбоотойгоос авхуулаад олон зүйлүүд байгаа. Гэхдээ 2025 оны төсөв дээр Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг хэвийн нөхцөлд оруулахад шаардлагатай хөрөнгүүд туссан байгаа юу? Энэ оны эцэс рүүгээ ийм хүнд байдалд ороод байдаг энэ үйл явц ер нь 2025 онд давтагдахгүй байх ийм бололцоо энэ төсвүүдээр туссан байгаа юу гэж ингэж асуух гэж байгаа юм? Яагаад гэвэл Эрүүл мэндийн даатгалын энэ тогтолцоо маань өөрөө эрүүл мэндийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг явуулахад нэн чухал санхүүгийн эх үүсвэр байгаа юм.

Мөн 3 дахь асуулт бол манай Байнгын хороо дээр яригдсан асуудлууд байгаа. Ялангуяа эрүүл мэндийн салбартай холбоотой Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн үүссэн тэр нөхцөл байдал, мөн дээрээс нь энэ Байнгын хороо дээр яригдсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын төсөв, санхүүтэй холбоотой асуудлууд, дотоод зохион байгуулалттай холбоотой асуудлууд. Энэ ерөнхий газартаа 70 хувь нь ажилладаг, орон нутагтаа цөөхөн хэдхэн хүн ажилладаг ийм тогтолцооноос шалтгаалаад эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа тэр болгон хурдан шуурхай явж чаддаггүй, оновчтой байдаггүй, орон нутгийн ачаалал нь хэт ихээс болоод олон зүйлүүд нь орхигддог эд нар ийм зүйлүүд гарч байгаа юм байна лээ.

Тэгэхээр үүнийг 2025 оны төсөв дээр төсөвлөхдөө яаж харж байгаа вэ? Яагаад гэвэл Байнгын хороо дээр танилцуулахдаа энэ асуудлуудыг 2025 он дээр

бол нэлээн анхаарна гэсэн ийм зүйлүүд яригдсан учраас 25 оны үйл ажиллагаа энэ төсөв хөрөнгөтэй шууд холбоотой учраас энэ Байнгын хороо дээр танилцуулагдсан асуудлууд төсөв дээр суухдаа яг тэр ярьсан шигээ төлөвлөөд сууж чадсан болов уу гэдэг ийм асуултыг асууя гэж ингэж бодож байна.

**Л.Энхнасан:** Жавхлан сайд хариулна уу?

**Б.Жавхлан:** Хариулах нь зөв дөө, уг нь. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөв бол өөрчлөгдөөгүй байгаа. Өмнө танилцуулсан яг энэ хэмжээндээ байгаа. Тийм учраас ямар ч байсан энэ жилийн нөхцөл байдал бол даамжирч ямар ч байсан муудахгүй. Тэгэхдээ алдагдалтай хэвээр үргэлжилж байгаа. Үүнээс болж эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээ дээр эрсдэл гарах уу, үгүй юу гэдэг дээр салбарын сайд л нь хариулах нь зөв байх. Тийм. Манай мөн Төсвийн бодлогын газрын дарга Санжаадорж нэмж тоон мэдээлэл өгнө.

**Л.Энхнасан:** Санжаадорж ажлын хэсэг 4 номерын микрофонд. Дараа нь Мөнхсайхан сайдын микрофоныг нээж өгнө үү.

Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Нийгмийн бодлогын байнгын хороонд бол харьяалагдаж байгаа 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн гол төсөв байгаа. Эрүүл мэндийн сайдын багц, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц. Эдгээр байгууллагуудаас бол нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын санг бол огт хасаагүй. Эдгээр сангууд бол хасалтгүй явж байгаа.

Бусад яамны аппаратын зардал болон бусад төсөвт байгууллагуудын зардлаас бол зарчмаараа 10 хувиар буурч төсөв өргөн баригдсан байгаа.

**Л.Энхнасан:** Мөнхсайхан сайдын микрофонд өгнө үү.

**Т.Мөнхсайхан:** Бүх гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд манай эрүүл мэндийн салбараас, санхүүжилтээс 36,8 тэрбум хасагдсан. Энэ нь бол Эрүүл мэндийн даатгалын сангаас ямар нэгэн хасагдалт хийгдээгүй. Тэгэхээр энэ өмнөх оныхоо санхүүжилтээс 360 орчим тэрбумаар нэмэгдсэн байгаа учраас өнөөдрийн үүсэж байгаа нөхцөл байдлыг ирэх жилд давтахгүй байлгах энэ боломж тодорхой хэмжээгээр бүрдсэн гэж хэлж болно. Гэхдээ эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн асуудлыг бүрэн утгаар нь шийдье гэх юм бол энэ дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувь руу хүрэх зайлшгүй шаардлагатай. Өнөөдрийн энэ тавигдсан байгаа санхүүжилт бол ер нь дотоодын нийт бүтээгдэхүүний нэг 3 орчим хувьтай л тэнцэхүйц хэмжээнд байгаа. Гэхдээ бид нар ч цаашдаа энэ санхүүжилтийг нь нэмэгдүүлж байгаа боловч нөгөө талдаа энэ Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн оновчтой байдал .../минут дуусав/

**Л.Энхнасан:** Микрофон, нэмэлт минутыг нь авъя, 2 минут.

**Т.Мөнхсайхан:** Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж байж, 2 талаасаа арга хэмжээ авч байж, энэ нөхцөл байдал маань сайжрах болов уу гэж бодож байгаа. Тэгэхээр ирэх жил бол Эрүүл мэндийн даатгалын сангийн нөхцөл байдал сайжирна гэж харж байгаа.

Тэр 36,8 тэрбум төгрөг хасахдаа дийлэнх нь сайдын багцад байгаа нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн бодлого, арга хэмжээнээс хасагдсан байгаа. Жишээ нь ХӨСҮТ-ийн тандалт судалгаанаас 1,9 тэрбум, СЭМҮТ-ийн сандал судалгааны ажлаас 0,8 тэрбум, ЭХЭМҮТ-ийн тандалт судалгаанаас гэхэд 0,5 тэрбум гэх мэтчилэн энэ нийгмийн эрүүл мэндийн бодлого, арга хэмжээнээс хасагдсан. Яах вэ, хэдийгээр хасагдсан байгаа боловч өнгөрсөн оны, энэ оны нийгмийн эрүүл мэндийн бодлогод тусгагдаж байгаа төсвөөс илүү их төсөв нь бол нэмэгдсэн гэж хэлж болохоор байгаа ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** 2 минутыг нь өгнө үү, нэмээд, сайдын микрофон.

**Т.Мөнхсайхан:** СЭМҮТ-ийн хувьд бол ер нь тэнд байдаг байнгын асрамжид байх шаардлагатай сэтгэцийн эрүүл мэндийн хувьд эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай улсууд, нийт орных нь бараг 30 орчим хувийг эзэлж, тэнд байнгын амьдардаг шахуу ийм болчихсон байж байгаа. Энэ байдлаас бид нар салж, үүнийг нийгмийн хамгааллынх нь чиглэл рүү нь шилжүүлэхгүй бол энэ СЭМҮТ дээр үүсэж байгаа нөхцөл байдал маань цаашдаа бүрэн гүйцэд шийдэгдэхээргүй байгаа. Хэдийгээр энэ тогтмол гарч байгаа зардлуудыг санхүүжилтэд нэмж суулгаад явж байгаа боловч үүнийг сууриар нь шийтгэхийн тулд цаашдаа асран хамгаалах хүнгүй, сэтгэцийн эрүүл мэндийн хувьд өөрчлөлттэй, эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай улсуудыг нийгмийн халамжийнх нь чиглэл рүү шилжүүлж байж, бид нар энэ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн өнөөдрийн үүсэж байгаа нөхцөл байдал бүрэн утгаараа арилна гэж ингэж харж байгаа. Үүнийг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай, сайдтай /минут дуусав/

**Л.Энхнасан:** Идэрбат гишүүн тодруулга.

**Ц.Идэрбат:** Яах вэ, 2 дахь нь энэ нийгмийн хамгаалал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц дээр, 2025 оны төсөв дээр энэ БНСУ дахь нийгмийн даатгалын алба, Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв гээд энэ огт төсөв тусгагдаагүй юм байна гэж ингэж харж байгаа.

Тэгээд яагаад энэ 2 ингээд төсөвгүй болов? Ялангуяа БНСУ-д бол Монголчууд маш ихээр ажиллаж, амьдардаг. Тэнд Монгол хүний эрх ашиг хөндөгдөж байна гэдэг зүйлийг мөн ЭСЯ байдаг юм уу, холбогдох төрийн байгууллагууд ийшээ хангалттай анхаарч чадахгүй байна гэдэг зүйлийг бол тэнд ажиллаж, амьдарч байгаа Монголчууд ярьдаг. Тэгээд энэ асуудал яагаад ингээд хасагдсан юм бэ гэдэг дээр би Энх-Амгалан сайдаас тодруулга авъя гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Энх-Амгалан сайдын микрофоныг өгье. Энх-Амгалан сайд та нөгөө СЭМҮТ-тэй холбоотой тэр халамж руу шилжүүлэх би танай яам руу тоот явуулсан байгаа. Түүнийг давхар хариулаад өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Энэ Солонгос улсад ажиллаж байгаа ажилчдынхаа эрх ашгийг хамгаалж ажилладаг. Ингээд энэ нөгөө Солонгосын хөдөлмөр эрхлэлтийн төвийн үйл ажиллагааны зардал нь яг төсөв дээрээсээ биш өөрсдийн нөгөө эх үүсвэрээсээ тодорхой тэнд нөгөө ажиллаж байгаа Монгол ажилчдын төлж байгаа НДШ бүрдүүлж байгаа НДШ-ээсээ ерөнхийдөө тэр эх үүсвэрээс үйл ажиллагааныхаа зардлаа нөхөөд явдаг. Ийм л юм байна лээ. Тийм.

Тэгэхээр энэ дээр бол яг нөгөө төсвийн юман дээр бол яг энэ үйл ажиллагааны төвийнх нь үйл ажиллагааны зардал тусдаггүй гэсэн үг. Энэ бол нөгөө нийгмийн даатгалын сангийн нөгөө том төсөв дотроо явдаг. Нэгд.

2-т бол юуны Японыг бол юу яачихсан юм байна лээ, юуны хуучин, тусдаа төв байсныг нь татан буулгаад, тэгээд ЭСЯ-тай нэгтгэчихсэн. 2 атташег нь бол ЭСЯ руу ингээд үйл ажиллагааг нь нэгтгэчихсэн юм байна лээ. Ер нь яах вэ, бид нар энэ Япон, Солонгос ингээд олон ажиллаж байгаа Австрали, юу Чех гээд ингээд нэг олон Монголчууд ажиллаж байгаа энэ газар дээр бол ерөнхийдөө бид нар цаашдаа энэ хөдөлмөрийн атташегийн ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэгдэл нэг минут өгнө үү.

**Л.Энх-Амгалан:** Яах вэ, энэ Монголчууд ихээр ажиллаж байгаа, тэгээд энэ нийгмийн хамгааллын гэрээнүүд хийгдэж байгаа юунууд байгаа. АНУ-д бол хийгдээгүй. АНУ, Чех, Солонгос, Япон, Австрали бол 20000 болчихож байгаа юм байна лээ. Тийм учраас яах вэ, Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр бол энэ хилийн чанадад ажиллаж байгаа Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах үүднээс ер нь цаашдаа нийгмийн хамгааллынх нь энэ асуудлуудыг шийдэх нэг хөдөлмөрийн атташег яг бид нар томилж ажиллуулъя гэсэн энэ зүйл, ирэх, тэгэхдээ энэ ондоо биш. Ирэх онд ирэх 4 жилд энэ хөдөлмөрийн атташены тогтолцоог хийе гэсэн нэг ийм зорилтууд тавьсан байгаа. Тэр хүрээндээ бид нар 25 онд бол бэлтгэл ажлаа хангаж ажиллана л гэж ойлгож болно.

**Л.Энхнасан:** Сайд аа, нөгөө СЭМҮТ-ын асуудал дээр нэг хариулаад өгөөч. Тийм, СЭМҮТ-д нэг 244 хүн байнгын оршин суудаг гээд байгаа, тийм. Яам руу тоот явуулсан байгаа, түүн дээр хариулах, ажлын хэсэгт хариулах хүн байна уу.

Тэгвэл Нарантуяа-Нара гишүүн асуултаа асууна уу.

**М.Нарантуяа-Нара:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хөрөнгө оруулалтыг тодорхой асуудал хуримтлагдсан салбарт илүү ач холбогдол өгөх шаардлагатай байна гэсэн ийм зөвлөмжийг гаргасан байна. Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой яг одоо үүсээд байгаа нөхцөл байдал, сайд хэлж байна л даа. Эрүүл мэндийн даатгалын сан 360 орчим тэрбумаар нэмэгдэнэ. Дараа жил бол энэ алдааг давтахгүй гээд ингэж ярьж байна. Тэгвэл яг одоо энэ үүсчихсэн байгаа 2024 оны эцсийн байдлаар ахмад настан, ялангуяа зайлшгүй хэрэглэх шаардлагатай эм, эмийн бүтээгдэхүүнээ хөнгөлөлттэй үнээр авдаг энэ юугаа авч чадахгүй байгаа нөхцөл байдал үүсээд маш их гомдол санал ирж байна л даа.

Тэгэхээр энэ асуудал 2025 оны 01 дүгээр сарын 01-нээс бүрэн шийдэгдэх үү. Үлдсэн энэ 20-оод хоногт энэ эмээ хөнгөлөлттэй үнээр нь авч чадахгүй байгаа ахмадуудын асуудал яаж шийдэгдэх вэ гэдэг асуултыг ЭМЯ-наас асуумаар байна.

Тэгээд дээрээс нь энэ тогтоолтой холбоотой Сангийн яамнаас асуух асуулт байна. Энэ ШУТИС Механик тээврийн сургуулийг Хөшигтийн хөндийд, тэгээд ХАА-н сургуулийг Дархан хотод нүүлгэн шилжүүлэх, хичээлийн байр, оюутны болон багш ажиллагсдын энэ бүх холбогдох урсгал зардал, нийгмийн асуудал, хөрөнгийн зардлыг шийдвэрлэх, нүүлгэн шилжүүлэх гээд ингээд чиглэл авсан байна шүү дээ

тийм ээ. Үүнийг ямар санхүүгийн эх үүсвэрээс юу, шийдвэрлэх гэж байгаа юм бол оо?

Тэгээд 2 дугаарт нь болохоор нийслэл Улаанбаатараас хотоос шилжүүлэн байршуулах боломжтой төрийн байгууллагуудыг орон нутаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжид нүүлгэх гэгчхсэн байна. Энэ дээр ямар төрийн байгууллагуудыг онцолж оруулсан байгааг юу асуумаар байна.

Тэгээд энд нэг зүйл байгаад байгаа. Энэ юу, 10 хувь хүртэлх хувиар бууруулах энэ зүйлд энэ жишиг норматив тогтоосон шийдвэрийг өөрчлөх болон орц, гарцыг багасгах, хамрах хүрээг хумьж хяналтын тоог бууруулах гэсэн дээр. Үүнийг яг яаж эрэмбэлсэн юм бол оо? Тэгээд энэ норматив жишиг зардлаас юу яах, бууруулах зүйлд нь нөгөө Хүүхэд хамгааллын норматив зардлын мөнгө орчихсон явж байгаа юм биш байгаа? Энд жишээлбэл ингэж байна шүү дээ.

6 дээр нь нийгмийн халамжид шалгуурыг оновчтой болгох, хөнгөлөлттэй үйлчилгээний давхардлыг арилгах, халамжаас хөдөлмөрт шилжих хөтөлбөр хэрэгжүүлэхээр нийгмийн халамжийн сангийн зардлыг 1,3 хувиар бууруулсан байна л даа. Энэ дээр яг ямар ямар хөтөлбөрийг ямар, ямар, одоо, юунаас нь хасна гэж заасныг нийгмийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдаас тодруулмаар байна?

**Л.Энхнасан:** Нөгөө гишүүний асуусан асуулт маань нөгөө, 2 дахь нөгөө хэлэлцэх асуудал байгаа. Тийм. Тэгэхээр тэр үед нь асуух уу? Эхнийх нь асуулт нь сайд Жавхлан сайд хариулна уу.

**Б.Жавхлан:** Салбарын сайд нь хариулахгүй юм уу.

**Л.Энхнасан:** Салбарын сайд юу, Мөнхсайхан сайд хариулна.

**Т.Мөнхсайхан:** Энэ хөнгөлөлттэй эмийг ер нь 20 онд нэлээн томоохон өөрчлөлт хийж, энэ ахмадууд сар болгоны эхний өдрүүдэд очерлож, дугаарлаж байж, хөнгөлөлттэй эмээ авдаг байсан энэ асуудал цэгцэрч, аятайхан болсон. Одоо бид нар энэ 2 дахь шатны өөрчлөлтүүдийг хийж байгаа. Энэ дээр бид нар өшөө энэ ахмадуудын тэтгэврийн хэмжээтэй уялдаад, энэ хөнгөлөлттэй авч байгаа эмийн хэмжээг ахмадуудын болон бусад иргэдийн санхүүгийн эрсдэлд орохгүйгээр энэ хөнгөлөлттэй эмийг яаж зөв болгох вэ гэдэг 2 шатны ажил, 2 дахь шатны ажил маань хийгдэж байгаа.

Одоогийн үүсчхээд байгаа нөхцөл байдал маань бол ер нь энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн үүссэн нөхцөл байдалтай холбоотой. Гэхдээ энэтэй холбоотой хөнгөлөлттэй эм олгодог эмийн сангуудад санхүүжилтийг өнгөрсөн 7 хоногт олгосон байгаа. Ингээд энэ асуудал маань ирэх оны эхний улирлаас авхуулаад шийдэгдээд явна. Шийдэгдээд явахдаа өшөө илүү чанартай эмийг бид нар нэгдсэн журмаар хэлцэл хийж, хувийн хэвшилтэйгээ хамтарч, гаднын чанартай юмнуудыг оруулж ирэх энэ бодлого маань хийж хэрэгжиж байгаа.

Тэгэхээр энэтэй уялдуулаад энэ ийм хөнгөлөлттэй олгож байгаа ялангуяа эмүүд дээр үнийн хувьд өшөө бол их хөнгөлөлт ирэх энэ боломж бололцоонууд бүрдэж байгаа.

Тийм учраас ирэх оны эхний улиралдаа багтаагаад энэ ахмадуудын авдаг хөнгөлөлттэй эм хэвийн олгогдох, эргээд өшөө үнийн хувьд бол өшөө бууралт бий болох энэ боломжууд бүрдсэн гэдгийг хэлье.

**Л.Энхнасан:** Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу?

**С.Эрдэнэбат:** 2025 оны төсөв дээр хуулиар заавал ч үгүй гарах ёстой зардлуудыг эрэмбэлж оруулж ирэх ёстой. Би дахиад нэг тодруулга хүсээдэхье. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль дээр нийт төсөв захирагч нар нийт зардлынхаа 0,5 хувийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд зарцуулна гээд хууль байгаа. Энэ манай асуудал хариуцсан салбарууд дээр хэр байгаа вэ? Энэ яагаад үүнийг хэлж байна вэ гэхээр одоо хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэдэг энэ хувцсаар төсөөлдөг энэ байдлаа болих хэрэгтэй байгаа юм. Ялангуяа манай энэ Улаанбаатар хотыг аваад үзэх юм бол үндсэндээ энэ утааны хордлогод бол наад иргэдийн чинь хэдэн хувь нь орж байгаа билээ? Утааг өөрчилнө, яана гэж улс төржүүлнэ гэхээсээ илүү энэ богино хугацаанд яаж энэ хүүхэд, ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийнхээ эрүүл мэндийг хамгаалах вэ гэдэг энэ асуудал дээр бол зардал тавих, үүний зарим зардлын хэсэг нь бол орох зайлшгүй шаардлагатай.

2 дугаарт, Эрүүл мэндийн даатгалын санд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор 0-18 насны хүүхэд болон ахмад настай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн даатгалыг төр хариуцна гээд төлж байгаа. Энэ мөнгөнд 04 сарын 01-нээс хэрвээ ингээд хэрэгжиж явж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр яг хэдэн төгрөг байх вэ? Өөр өөр тоо яриад байгаа, байх шиг байна. Хэдэн төгрөгийг тэр сангуудад өгөх вэ? Үндсэндээ Эрүүл мэндийн даатгалын санд л орох мөнгө байгаа.

Дараагийнх нь гадаадад ажиллах хүч гээд энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөв дээр ихэнх нь гадаадад ажиллах хүчнээс орж ирдэг мөнгө л дөө. Тэгэхээр ирэх жилүүдэд гадаадаас ирж байгаа ажиллах хүчнээсээ төлбөр авах юм уу, авахгүй юм уу. Маш олон гишүүд үүнийг авмааргүй байна энэ тэр гээд юм яриад байсан. Энэ тал дээр бол тодруулга авмаар байна.

Дараагийнх нь ахмадуудаас маш их ийм санал ярьж байгаа юм. Нэг сувиллын хөнгөлөлт гээд 30 мянган төгрөгөөр бараг 10 жил байлаа. Үүнийгээ ер нь нэмэх үү, үгүй юү? Энэ мөнгөнд нь тааруулна гэдэг 30 мянга гэдэг чинь үндсэндээ бараг зүгээр нэг өдрийн бараг нэг хоолны л мөнгө шүү дээ. Энд нь тааруулж байна гээд ахмадуудыг 10 хоног байсан 7 болгосон, тэр хоол, сувилал гээд яриад байх юм байхгүй ийм болсон. Тэгэхээр энэ тал дээр нь хөрөнгө мөнгийг нь нэмж тавих тавьсан уу, тавиагүй юу. Эс үгүй бол яг энэ хэвээрээ байх уу.

Дараагийнх нь энэ аудитынханд 1 зүйлийг хэлмээр байгаа юм. Яах вэ, хэдэн тооны нийцлийг бол хооронд нь яриад тавьчихаж байгаа юм. Энэ нийцлийн аудит буюу энэ хуулиар зайлшгүй гаргах ёстой, мөн иргэд олон нийтээс тавьдаг өнгөрсөн төсөв дээр болон ирээдүйд тавьж болзошгүй ийм зүйлүүд дээр манай аудитынхан цаашдаа харж дүгнэж байх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол зөвхөн тоо талаас нь бол хардаг, аудитынхан бол тэр хууль тогтоомжид байгаа ийм ийм зардлуудыг тусгаагүй байна. Үүнээс болоод ийм ийм эрсдэл учирч болзошгүй байна. Энэ тэр гэдэг энэ талаас нь та бүгд ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Ажлын хэсгээс Сангийн сайд Жавхлан хариулна уу. Санжаадорж хариулах уу? Микрофон 4 дүгээр микрофон.

Сангийн яам Санжаадорж Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Хууль дээр бол төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0,5 хувиас доошгүйг бол хөдөлмөрийн аюулгүй байдал, энэ дундаа бол яг таны хэлж байгаа тэр хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчин энэ тэр гээд заасан байдаг. Энд бол мөнгө зарцуулна гэхээд байгаа юм. Тэгэхдээ энэ өөрөө бол батлагдсан төсвөөсөө зохицуулалт хийх замаар зарцуулах ийм асуудал болчихоод байгаа юм.

Тэгэхээр бид бол яг энэтэй ижилхэн төсвөөсөө зарцуулах ёстой 2 өөр тусдаа зардал байдаг. Нэг нь бол гамшгийн зардал, гамшгаас хамгаалах зардал, нөгөөх нь бол Ахмадын сангийн зардал байдаг. Ахмадын сангийн зардал дээр бол Сангийн яамнаас бол тодорхой ажлууд хийгээд төсөвт байгууллагуудыг үүрэгжүүлэх талаар ажиллаж байгаа. Яг энэтэй ижилхэн байдлаар бид энэ хөдөлмөр хамгааллын зардлыг бол ингээд өргөжүүлэх ажил ирэх жилээс хийнэ гэж бодож байгаа. Гэхдээ нэг ялгах ёстой зүйл нь бол мэдээж хэрэг өвлийн улиралд энэ хордлогын асуудал бол байгаа. Гэхдээ тухайн байгууллага хэдэн хүнтэй байх, ямар зардалтай байх, аль зардлаас нь тооцох вэ гэдэг асуудлуудыг бид нар жишээ нь тооцох хэрэгтэй болчихоод байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд бол жишээ нь ЭМЯ-ны хувьд ч ялгаагүй, сангууддаа өгөх татаас нь орж ирэхээр асар том зардал болчихдог. Эндээс 0,5 хувь гээд тооцох юм бол шал өөр зардал болчихно.

Тэгэхээр бид нар үйл ажиллагааны зардлыг нь яаж тусгаж, илүү тодорхой болгох вэ? Хууль бол мэдээж хэрэг батлагдсан хуулийг бид хэрэгжүүлэх ёстой. Тэгэхдээ зөв хэрэгжүүлэх, тэр нь гол нь үр дүнд хүрдэг энэ талаас нь бид нар харах нь зүйтэй гэсэн тийм байдлаар явж байгаа.

2 сангуудад бол улсын төсвөөс татаас өгч байгаа. Татаас бол ямар байдлаар тооцогдож байгаа вэ гэхээр хуульд заасан шийдвэрийн дагуу бид нар төр хариуцах ёстой нийгмийн зорилтот бүлгүүдийн шимтгэлийн зардлыг бол төрөөс хариуцаж өгч байгаа. Ирэх жилийн төсөв дээр бол бид нар 660 мянган төгрөгөөр шимтгэлийн юуг бодож тавьсан байгаа. Зүгээр Эрүүл мэндийн даатгалын сангийн хувьд бол таны хэлж байгаатай бол санал нэг байна. Ахмадын болон хүүхдийн 0-18 настай хүүхдийн шимтгэлийн хэмжээг бол бид хууль дээр хамгийн доод тал нь 1 гэж байгаагаас биш түүнээс дээшээ тогтоох боломжтой байгаа. Үүнийг Засгийн газар дээр илүү тогтоогоод явах боломжтой гэж үзэж байна. Яагаад гэхээр Эрүүл мэнд даатгалын сангаас хамгийн их зардал авч байгаа хэсэг маань бол яг энэ 2 бүлгийн хэсэг маань байгаад байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Жавхлан сайд нэмж хариулт өгье.

**Б.Жавхлан:** Түрүүн Нарантуяа-Нара гишүүний асуулт дээр зүгээр нэмж мэдээлэл өгөх гэсэн юм. Эрүүл мэндийн даатгалын бид гүйцэтгэлд суурилсан тогтолцоо руу 2020 онд орсон юм, анх. Өөрөөр хэлбэл сангийн тогтолцоо руу гэсэн үг. Тэгэхээр энэ сангийн онцлог бол өөрөө хуримтлагддаг сан биш. Тухайн жилдээ орлого бүрдүүлэлтээрээ сангаа бүрдүүлээд, тухайн жилдээ 0 үлдэгдэлтэй гарах. Өөрөөр хэлбэл бүгдийг нь зарцуулж дуусгах ёстой ийм сангийн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл тус салбарын бүхий л эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ энэ сангаас санхүүждэг гэсэн үг. Даатгалаараа дамжаад. Нэг суурь зарчим маань энэ.



2 дугаарт, та түрүүн энэ жилийн алдааг хойтон жилд давтахгүй гэчих шиг боллоо. Тэгэхээр энэ алдаа гэх үү, юу гэж үзэх вэ? Энэ хаана анх, хэдэн онд үүссэн бэ гэхээр 2021 оны 3 дугаар улиралд нөгөө айхтар ковидын маань тэр омикрон хувилбар гарч ирэхэд хамгийн хүнд үеэ өнгөрүүлсэн ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт 1 минут.

**Б.Жавхлан:** Тийм, хамгийн хүнд үе тэнд өнгөрсөн. Ингээд нэмэлт 200 гаруй тэрбум төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сан дээрээс алдагдал хүлээж гаргасан байгаа. Үүнийг би бол алдаа гэж хэлмээргүй байгаа юм. Энэ бол Монголын ард түмэн, Монгол Улс маань, ялангуяа Азийн улс орнуудаас дунджаар 1 жилийн өмнө бид ногоон бүс рүү шилжиж, бүх үзвэр, үйлчилгээгээ, хөдөлгөөнөө нээсэн байдаг. Үүний төлөө гаргасан би бодлогын зардал гэж үздэг. Түүнээс хойш сан бол нэлээн алдагдалтай явсаар байгаад энэ жил алдагдал үргэлжилсэн. Ирэх жилээс хэвийн үйл ажиллагаандаа орно оо гэж ингэж төлөвлөж байгаа.

Тэгэхээр Эрүүл мэндийн даатгалын сан ирэх жил бол бүх зардлаа бүрэн санхүүжүүлэхээр ингэж төсөвлөсөн байгаа. Ер нь Эрүүл мэндийн даатгалын сан маань 60 хувь нь татаасаар явдаг, татвар төлөгчдийн мөнгөөр нөхөгддөг гэсэн үг. 40 хувь нь Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээрээ дөнгөж бүрдэж явдаг. Ковидын үед 1,3 их наяд байсан Эрүүл мэндийн даатгалын сан маань ирэх жил 2,3 их наяд болж ингэж ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэгдэл 1 минут. Болсон уу, сайд.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар Энх-Амгалан сайд хариулах уу? Сангийн яам хариулах юм уу. Хариулчихлаа сая.

Тодруулга Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Хөдөлмөрийн аюулгүй байдлын юун дээр гарах ёстой хуулийнх нь юу би андуураагүй бол 3,5 тэрбум системийн хэмжээнд байна л гэж хэлж байсан. Магадгүй ирэх жил томоохон хэмжээний осол аваар нийгмийг хамарсан хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудал гарвал энэ зардал тавиагүй, асуудал хариуцсан хүмүүст би хариуцлага тооцох асуудлыг ярина шүү. Яагаад гэхээр байх ёстой хуулийнх нь юмыг тавиагүйгээр тэгээд дараа нь асуудал гарчихсан хойно нь бие бие рүүгээ буруу чихэж улс төржицгөөдөг, 1.

2 дугаарт, хүүхдийн эрүүл мэндэд сая Жавхлан сайд хэлж байна. Тэр нэг банкнуудаас авах ёстой 50 хэдэн тэрбум төгрөг байгаа. Түүнийг аваад ядаж энэ хүүхдүүддээ нэг сард тэр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнийх нь нэмэгдсэн хэмжээгээр нь тооцоод нэг сан руу нь хэдэн төгрөг өгөөд, Эрсдэлийн сан болгож тавиад яг энэ ханиад томуутай ийм хүнд үед нь хэрэглээрэй гээд ингээд тавьчихаж болохгүй юу? Тэрийгээ хэдэн хувийг нь авъя гэж тусгасан байгаа вэ?

**Л.Энхнасан:** Ажлын хэсэг Жавхлан сайд хариулна уу?

**Б.Жавхлан:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Ингээд яг салбар салбарынхаа өөрсдийнхөө зардлыг нэхдэг юм. Хууль тогтоомжийн дагуу төсөвт суух ёстой 4,5 их наяд төгрөгийн зардал сууж чадаагүй байгаа, 2025 онд. Гэтэл энэ жил төсөв тэллээ, зардал нь нэмэгдлээ, бүр задарлаа гээд ингээд ярьж байгаа.

Ингээд бид хориг тавиулаад ингээд дараагийнхаа төсвийг дахин боловсруулж ингэж оруулж байгаа.

Тэгэхээр эдгээр хуулиудыгаа нэг ганц одоо нэг хууль сугалж харахгүйгээр 1, 1 зарчим дээрээ маш сайн ярилцаад, одоо энэ хүлээгдэж байгаа, одоо энэ хуулийнхаа дагуу төсөвт тавигдчихсан байгаа энэ 50 гаруй хуулиудыг салбар салбарын хуулиудыг эргэж харах хэрэгтэй. Одоо яг ингэж яригддаг. Манай салбарын энэ зардлыг тавихгүй бол сахилга юу тооцно, арга хэмжээ ярина гээд Засгийн газар луу ингэдэг. Хөдөлмөр аюулгүй байдлын асуудал бол тэгээд төсвийнхөө хэр хэмжээнд л боломжоороо салбар салбарууд дээр тавигдсан байгаа. Энэ талаар сайд нар дурдана ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт минут.

**Б.Жавхлан:** Тэр алдагдал болсон, тэр авлагуудын талаар хэрхэн яаж хөөцөлдөж байгаа талаараа сайд нар ярих байх. Ер нь бол үүнийг юу гэдэг юм, авлагыг эрэмбэлж гэдэг ойлголт байж болохгүй. Бүгдийг нь л барагдуулах ёстой.

**Л.Энхнасан:** Болсон уу, тодруулга авах уу, болчихсон уу.

Бейсен гишүүн асуултаа асууна уу?

Тодруулга 1 минут Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Жавхлан сайд аа, яах вэ, энэ нөгөө хөдөлмөрийн аюулгүй байдал гэдэг нэг салбарын асуудал биш л дээ. Нийт хүмүүсийн асуудал учраас би энэ дээр санаа зовоод байгаа юм. Яагаад гэхээр маш олон газруудаас хөдөлмөрийн аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх энэ чиглэлээр юм хийе гэхээр ерөөсөө мөнгө тавьдаггүй, байдаг ч үгүй гээд. Тэгээд энэ тал дээр нэг жоохон нэмэх боломж байна уу. Яах вэ, нийт зардлаараа бол 130 тэрбум төгрөг гээд их хэмжээний мөнгө л дөө. Энд хүрэхэд бол хэцүү гэдгийг хэлмээр байгаа юм.

2 дугаарт, тэр эрүүл мэндийн асуудал гэж байгаа дээр сая яг бодит байдал дээр оны сүүлээр гэхээр мөнгө байхгүй болчихсон, эрсдэлийн сангаа зараад дуусчихсан, эмнэлэгт хүүхдүүд ор дэлгээд хүрэлцээгүй байх шиг байгаа. Ганцхан эрүүл мэндийн сайдын асуудал бол биш. Энэ утгаар нь нэгэнт тодорхой хэмжээгээр төр өөрөө даана л гэж байгаа юм чинь түүнийг нь даасан шиг даагаарай. Хэрвээ хүрэхгүй байгаа бол тэгвэл тэдэн хувийг нь даая гэдэг хуулиа л батлаад өгчих. Хүүхдийн болон ахмадын эрүүл мэндийн даатгах санг төрөөс 80 хувийг нь хариуцъя л гээд хэлчих.

**Л.Энхнасан:** Илүү, санал байна, тийм ээ. Бейсен гишүүн асуултаа асууна.

**Б.Бейсен:** Энэ 25 оны төсөв орж байгаатай холбоотой эмч хүний хувьд эрүүл мэндийн салбар, Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн санхүүжилтдээ санаа зовж явдаг нэг юмаа ярья гэж бодож байна. Ер нь төсөв хүрэхгүй, тэгээд эмнэлгийн тусламж үйлчилгээ доголддог ийм эрсдэл үүсдэг л дээ. Одоогоор энэ аймгуудын бүх нэгдсэн эмнэлэг, хотын нэгдсэн эмнэлгүүд, хотын клиникийн том эмнэлгүүд, бүгд өртэй. Ер нь эд нар хэчнээн тэрбумын өртэй юм бол энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

Нөгөө талаар сая 300 хэдэн саяар нэмэгдсэн. Бид эрүүл мэндийн сайдад Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан, даатгалын, нөгөө талаар Эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг сайдын эрх хэмжээний хүрээнд зарцуулах талын түрүүн нэг Байнгын хороогоор нэг ярьсан. Тэгэхээр энэ сум, багийн эмийн сангийн асуудал байж байна. Сая хөнгөлөлттэй эмийн асуудал яригдаж байна. Үүнийг ер яаж реформ хийх гэж бодож байна? Сая нэмэгдсэн юунаасаа гаргаад шийдэх гэж байна уу? Урьдахаараа тэр чигээрээ явах уу? Саяын эрсдэлийн сан Эрүүл мэнд даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээр тэгээд энэ өр зээлээ хаах гэж байна уу? Сая нэмэгдсэн 360 хэдэн тэрбум маань тэр саяын клиникийн эмнэлгүүдийг өр зээлд тавих уу? Энэ талаар тодорхой мэдээлэл авъя.

2 дугаарт, Баян-Өлгий аймагт том нэгдсэн эмнэлэг ашиглалтад орж байгаа. Үүний тоног төхөөрөмжийн асуудлыг шийдсэн юм болов уу. Энэ талаар асууя.

**Л.Энхнасан:** Мэндсайхан сайдын микрофоныг өгнө үү. Сайдын микрофоныг өгнө үү. Мэндсайхан сайдын. Уучлаарай Мөнхсайхан сайдын.

**Т.Мөнхсайхан:** Түрүүн тэр хүүхдийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь даамаар байна гээд байх юм. Хүүхдийг бол бүгдийг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 100 хувь даагаад, ялангуяа энэ томуугийн үед бол бүх тусламж үйлчилгээг хүргэж байгаа. Яалт ч үгүй энэ дээр энэ томуугийн дэгдэлт ихтэй байгаа. Бид нар бол бэлтгэл ажил маш сайн хангасан. 2400, 500 ор дэлгэж бэлдсэн. Томуугаас сэргийлэх арга хэмжээнүүдийг бүгдийг авсан. Вакцинжуулалтыг маш сайн хийсэн боловч яалт ч үгүй энэ хүйтний улиралтай холбоотой энэ жил дэгдэлт өндөр байгаа учраас ачаалал ихтэй байна. Цаашдаа ч ачаалал нэмэгдэх шинжтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын санд өнөөдрийн байдлаар ингээд он даваад 25 оны 1 сарын 1 хүртэл бол ер нь нийт өрийн хэмжээ нэг 330 тэрбум болохоор байгаа. Ирэх оны Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэгдэл бол нэг 360 тэрбум байна. Тэгэхээр энэ дээр бид нар зөв зохион байгуулалт, зохицуулалтыг хийвэл ирэх жил энэ Эрүүл мэндийн даатгалын санд өнгөрсөн 3 жилийн хугацаанд үүсээд байгаа энэ хямрал маань арилах боломж байна гэдгийг түрүүн тайлбарлаж хэлсэн.

Энэ сумын эмийн сангууд янз бүр байгаа. Заримд нь хувийн эмийн сангууд байна. Зарим эмнэлгүүдэд эргэлтийн эмийн сан, зарим сумын ЭМТ-үүд өөрсдөө эмийн сантай. Ингээд зарим сумууд бараг эмийн сангүй ийм нөхцөл байдал байгаад байгаа. Тэгэхээр бид нар энэ нэгдсэн хэлцлийг гаднын эмийн үйлдвэрүүдтэй хийж, улсын хэмжээнд чанартай эмийг хямд үнээр нийлүүлэх энэ бодлого маань хэрэгжээд эхэлчихсэн. Эхний ээлжийн 5 эм маань ороод ирчихсэн. Дараагийн ээлжийн хавдрын 5 төрлийн эм бусад төрлийн эмүүд маань энэ сарын 20-оор орж ирэхээр байгаа. Тэгээд эд нарынхаа түгээлтийг бид нар бүх сумдад, бүх аймгуудад, Улаанбаатар хотын болон Монгол Улсын хэмжээнд бүх газар ижил нэг үнэтэй байхаар ийм төлөвлөлтүүдийг хийсэн. Үүний дагуу сумын эмийн сангууд бүгдээрээ бий болох энэ боломжуудыг бүрдүүлчихсэн гэсэн үг.

Дээрээс нь энэ цахим дэлгүүрт орж ирж байгаа бүх эмүүдийг байршуулж, ямар нэгэн сумын ЭМТ, аймгийн ЭМТ-үүдэд эмийн худалдан авалтыг тусад нь зарлаад байдаггүй, улсын хэмжээнд нэг эмийн үнийн бодлогыг хийж хэрэгжүүлэх ажил маань амжилттай явж байгаа. Энэ ирэх онд энэ маань жигдрээд явчихаар

бүх ард иргэд маань чанартай үнийг өшөө илүү хямд үнээр, чанартай эмийг өшөө илүү хямд үнээр хэрэглэх боломж нь бүрдээд эхэлчихсэн гэж ойлгож болно.

Бид нар цаашид энэ Баян-Өлгий аймагт нэгдсэн эмнэлэг ирэх онд шинээр ашиглалтад орж байгаа. Бас хэд хэдэн аймгуудад ер нь жишээ нь Дорнод аймагт Бүсийн оношлогоо эмчилгээний төв шинээр ашиглалтад орж байгаа. Үүний дараагийн тоног төхөөрөмжийн хангалт, хүний нөөцийн хангалтын ийм төлөвлөлт байхгүйгээс болоод өндөр үнэтэй барилга баригдсан боловч нөгөө хуучин барилгад байсан тоног төхөөрөмж, боловсон хүчнээрээ зүгээр нүүгээд орчихоор, тусламж үйлчилгээ сайжрахгүй, ард иргэдийн сэтгэл ханамж сайжрахгүй ийм л зүйл болоод байгаа юм.

Тэгэхээр бид нар цаашдаа энэ барилга барилаа гэхэд хүний нөөцийн бодлогыг нь яаж хэрэгжүүлэх юм, яаж тоног төхөөрөмжөөр хангах юм гэдэг бодлогоо зэрэг авч явахгүй бол ашиггүй энэ хөрөнгө оруулалтууд үүсэх эрсдэл маш их өндөр болчихоод байна.

Ирэх оны төсөв дээр бол хөдөө орон нутагт шаардлагатай тоног төхөөрөмжийг хангах 45 тэрбум төгрөг тусгагдсан байгаа. Үүнээс тодорхой хэмжээг нь Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэгт зарцуулах ийм төлөвлөлт гарсан. Гэхдээ бид нар зөвхөн 21 аймагт зөвхөн хавдрын тусламж үйлчилгээг сайжруулах, шаардлагатай тусламж үйлчилгээгээ хүргэдэг болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн санхүүжилт гэхэд л 38 тэрбум болж байгаа. Бид нар ирэх жил зөвхөн хавдрын тусламж үйлчилгээгээ сайжруулах хэмжээний л төсөв мөнгө байна гэсэн үг.

**Л.Энхнасан:** Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

**О.Саранчулуун:** Сайн байцаана уу. Төсвийн тогтвортой байдлын дүгнэлт зөвлөмжүүдийг ерөнхийдөө уншиж үзэхээр 3.6 болон 3.7 дээр төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа хэдий ч үр ашигтай байдал эргэлзээтэй байна гэдэг дүгнэлт л гараад байгаа юм. Тэгээд энэ эргэлзээтэй гэдэг энэ үг нь аль салбарынх нь ямар төсөл хөтөлбөр ямар зүйлээс нь гарч ирж эргэлзээтэй байсан юм бол оо гэдгийг нь бол тодорхой мэдээлэл байхгүй. Тэгэхээр би яах вэ, өөрийнхөө мэдэх хэмжээндээ энэ нийгмийн эрүүл мэндийн салбарын юмыг л харж байгаа юм л даа. Тэгэнгүүт Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуультай болсон манайх, маш ахицтай сайн хэрэг. Энэ хуулийн маань 5 дугаар зүйл дээр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, үйл ажиллагааны чиглэл гээд нэг ийм 8 чиглэл байгаа. Үүнийг бүгдээрээ мэдэж байгаа. Энэ 8 чиглэл дундаа нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг халдварт болон халдварт бус өвчний хяналтаар, орчны эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, шим судлал, нийгэм, сэтгэц, зан үйл, нөхөн үржихүйн эрүүл мэнд, нийгмийн эрүүл мэндийн лаборатори, ноцтой байдлын хариу арга хэмжээ гэсэн ийм 8 зүйл, заалттай үйлчилгээг бид нар хуульдаа тусгачхаад байгаа. Мэдээж энэ бол өнгөрсөн жилээс юу мөрдөж эхэлж байгаа шинэ хууль болов ч энэ жилийн төсөвт маань ер нь цаашдаа манайх 25, 6, 7 онд төсөвт тусгагдсан байдлаараа харахаар энэ үйл ажиллагаануудын хувьд бол тэгш бус харагдаад байна.

Нийгмийн эрүүл мэнд гэдэг Эрүүл мэндийн сайдын зардлын ангиллын багцыг харахаар их гол зардал нь бол халдварт болон халдварт бус өвчний хяналт дээр байгаад байгаа байхгүй юу. Эрүүл мэндийн сайдын багцын 32.1.1-ээс 32.2

дээр байна шүү дээ, тийм ээ. Мэдээж тэр бол хүүхдүүдэд чиглэсэн зонхилон тохиолдох халдварт өвчнөөс сэргийлж байгаа үйл ажиллагаа байгаа. Харин ахиад жоохон ухаад үзэхээр орчны эрүүл мэнд гэдэг ангилал дээр улсын төсвөөс 1,2 тэрбум төсөвлөсөн байгаа юм байна. Гэхдээ хэрэгжүүлэгч бүтцийн хувьд бол эрүүл мэндийн болон бусад салбар юм байна гэж би ойлгоод байгаа тийм ээ. Тэгвэл хүнсний аюулгүй байдал, шим судлал, нийгэм сэтгэц, зан үйл болон энэ 5.1.8-д тусгагдсан ноцтой байдлын хариу арга хэмжээг гэдэг дээр ер нь ямар зардал эрүүл мэндийн талаасаа тусгагдсан бэ? Жишээлбэл, энэ өнөөдрийн бид нарын жил болгон яриад байдаг утаа өөрөө ноцтой байдалдаа орох уу? Судалгаанаас аваад үзэхээр ноцтой байдлыг илтгэх хэмжээ, хэд хэдэн судалгаа дэлхийн ОУБ, Нэймээс ч гэсэн манай угаар судалгаа гээд ингээд гаргаад ирчихсэн байгаа. Ямар тохиолдолд ноцтой байдал гэж үзэх юм гэдэг дээр энэ зардал, төсөв тооцоолох дээр. Хэрвээ энэ ноцтой байдал юм бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөмжид өгсөн хөрөнгө оруулалтаа тодорхой асуудал хуримтлагдсан салбарт өгнө гэдэг энэ 3.6 чинь энэ утааны асуудалтай холбоотой орчны эрүүл мэнд болон энэ 5.1.8 руу чиглэх байсан уу?

Би нэг ийм зардлын хуваарилалтын зарчмын л зүйл ярьж байгаа. Бодлогын хувьд ер нь та бүхэн ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Нэмэлт 1 минутыг өгнө үү.

**О.Саранчулуун:** Тэгэхээр төсөв алдагдалгүй батлах том зургаараа улс оронд хэрэгтэй боловч бид нар ингээд эрүүл мэндийн зардлуудыг харахаар тийм ээ, эм рүүгээ явж байна. Эмнэлэг рүүгээ явж байна. Хэрвээ бид нар Нийгмийн эрүүл мэндийн хуультай болж энэ өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарна гэдэг том зорилгоо тавьж, тэр замаараа явахгүй юм бол нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнийхээ зардлыг бага тавьчихаад, тэгээд л эм, эмнэлгээ эмнэлгийн зардлаар явахаар чинь хүмүүс өвдөөд л зогсохгүй шүү дээ. Эмнэлэг, эмээ уусаар л байх болно, өвдсөөр л байх болно.

Тэгэхээр цаашдаа тэр бодлого барьж байгаа бол зардал дээрээ ер нь цаашдаа эрүүл мэндийн боловсрол олгох зардлаа нэмэх боломж үе шаттайгаар төлөвлөсөн үү тийм ээ. Бодлогын хувьд энэ дээр ямар зураглал байгаа вэ гэдэг дээр нэг тоймтой мэдээлэл өгөөч. Хэрвээ өнөөдөр мэдээлэл өгч амжихгүй байвал би энэ дээр илүү албан бичгээр Нийгмийн эрүүл мэндийн хуульд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой яг энэ ямар зардлуудыг төлөвлөж байгаа үе шаттайгаар байгаа вэ. Цаашдаа ямар бодлого барьж байгаа тухай мэдээлэл авах хүсэлт ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Мөнхсайхан сайд хариулна уу.

**Т.Мөнхсайхан:** Энэ бид нар нийгмийн эрүүл мэндийн бодлого гэж сүүлийн жилүүдэд нэлээн ярьсны хүчинд Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдсан. Нийгмийн эрүүл мэнддээ анхаарал хандуулдаг буюу өвчин үүсгэж байгаа шалтгаан, эрсдэл, хүчин зүйлтэй тодорхой хэмжээгээр тэмцдэг болсон. Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт элрүүлгийн тогтолцоог бий болгож, энэ рүү чиглэсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтууд тодорхой хэмжээгээр тавигдсан. Тэгэхээр цаашдаа энэ санхүүжилтийн хувьд бид нар энэ эмнэлгийн тусламж, үйлчилгээнээсээ нийгмийн эрүүл мэнд буюу өвчний сэргийлэлт рүүгээ илүү их шилжих ёстой нь зөв өө, түүнтэй санал нэг байгаа. Гэхдээ энэ маань үе шаттайгаар

шилжихгүй бол өнөөдөр манай улсын хувьд өвчлөл ихтэй байгаа. Ялангуяа зүгээр жишээ аваад үзэхэд хорт хавдар гэхэд жилийн хугацаанд 16 хувиар нэмэгдэж байгаа. Иймэрхүү нөхцөл байдалтай байгаа үед бид нар эмнэлгийн тусламж, үйлчилгээ рүүгээ санхүүжилт тавихаас өөр аргагүй.

Ирэх жилийн хувьд бол нийгмийн эрүүл мэнд рүү чиглэсэн санхүүжилт 50,4 тэрбумаар нэмэгдсэн байсан боловч энэ саяын сүүлд шинээр өргөн баригдаж байгаа төсөв дээр бол 36,8 тэрбумаар буурсан байна. Гэсэн хэдий боловч өмнөх оны буюу энэ жилийнхээс тодорхой хувиар нийгмийн эрүүл мэндэд тавигдаж байгаа зардал маань нэмэгдсэн. Цаашдаа бид нар ингээд жил болгон үе шаттайгаар тусламж, үйлчилгээнийхээ зардлаас нийгмийн эрүүл мэндийн бодлогын зардал руугаа шилжээд явах юм бол энэ маань маш зөв болно. Тэгэхээр энэ дээр бид нар нарийн тооцооллуудыг хийж байгаа. Аль төрлийн тусламж, үйлчилгээг бид нар илүү их нийгмийн эрүүл мэндийн бодлого руу нь шилжүүлж чадвал илүү их үр өгөөжтэй, өнөөдөр зарцуулж байгаа санхүүжилтүүдээс хэмнэлтүүдийг хийж болох вэ гэдэг энэ зүйл рүү шилжиж байгаа. Ингээд Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдсанаараа бид нар Өвчний хяналт, сэргийлэлтийн үндэсний төвийг байгуулах энэ ажилдаа орсон.

Сая өнгөрсөн хугацаанд яг энэ ковид буюу цар тахлын үед бид нарын хувьд авсан нэг сургамж бол энэ Өвчний хяналт сэргийлэлтийн үндэсний төв байж, нэг том нэгдсэн байгууллага байхгүй бол доошоо дүүрэг, аймаг, сумууд руугаа энэ онцгой нөхцөл байдал үүссэн үед хийж хэрэгжүүлэх ажил маань ингээд үр дүнгүй болох ийм эрсдэл байгаа учраас бид нар Өвчний хяналт сэргийлэлтийн үндэсний төвийг дүүрэг, аймаг, сумдын түвшинд нэг бүтэц зохион байгуулалттай байх энэ төлөвлөлт рүүгээ орчихсон ажиллаж байгаа. Энэ бүтэц зохион байгуулалтыг бий болгох чиглэлд нийгмийн эрүүл мэнд рүү чиглэсэн тодорхой төсөв, санхүүжилтүүд тавигдсан боловч саяын энэ урсгал зардлын 10 хувийн хасалтын хувьд тодорхой хэмжээгээр хасагдсан. Ийм зүйл байгаа. Гэхдээ бид нар энэ Өвчний хяналт сэргийлэлтийн үндэсний төвөө байгуулах ажил маань цаашдаа хийгдээд явна. Нийгмийн эрүүл мэнд рүү чиглэсэн, ялангуяа эрүүл мэндийн боловсрол олгох руу чиглэсэн энэ төсөв мөнгөө жил болгон илүү их өндөр хувиар нэмэгдүүлж явж байж, бид нар сууриараа цаашдаа эрүүл Монгол хүн бий болох үндэс суурь тавигдана гэдэг ийм бодлоготой явж байгаа.

**Л.Энхнасан:** Зөв, зөв. Ер нь нийгмийн эрүүл мэндийн салбарт бол бид нар манай Байнгын хороо нэлээн ач холбогдол өгч байгаа. Өмнө нь бид нар үүнийгээ л яг ярьж байсан. Одоо яалт ч үгүй ингээд 10 хувь бусад бүх салбараас хасагдаж байгаа учраас хасах гэж байгаа, харамсалтай нь хасагдаж байна. Тэгэхдээ ер нь энэ Нийгмийн даатгалын сан болон Эрүүл мэндийн сангаас хөдлөхгүй ингээд хүүхдийн мөнгө, тэтгэврээс бол хөдлөхгүй ингээд энэ төсөв маань үлдэж байгаад талархалтай байна.

Ингээд Саранчулуун гишүүн тодотгол авах уу? 1 минутад тодотгол авах уу?

**О.Саранчулуун:** Ер нь бол бид нар нийгмийн эрүүл мэндийн судалгаа, нийгмийн эрүүл мэндийн тандалт, нийгмийн эрүүл мэндээсээ мөнгө хасах хэмжээгээрээ тэдий хэмжээний бид нар өвчлөлд мөнгө зарцуулах хэрэгтэй л болно. Бид нарт өөр сонголт байхгүй. Тэгээд өвдсөн хүнд өгч байгаа эм, өвдчихсэн хүмүүст зориулсан эмчилгээ чинь илүү урт хугацааны зардал шаардсан, илүү тоног төхөөрөмж шаардсан, илүү хүний нөөц шаардсан эмнэлэг барихаас өөр

сонголтгүй болж байгаа байхгүй юу. Тэгэхээр өнөөдрийн энэ нийгмийн эрүүл мэндээ бид нар анхаараагүй орхиж ирсний үр нөлөөнд өнөөдөр бид нар Хавдрын эмнэлгээ 2 дахиа барихаас өөр аргагүй байдалд хүрч байгаа байхгүй юу.

Тэгэхээр цаашдаа ер нь нийгмийн эрүүл мэндийнхээ зураглалаа нэлээн томоор гаргачхаад, урдаа гарч байгаа бол зардал төсөв дээрээ нэг ийм пропорцыг нь барьж ингэж төсөвлөмөөр байна. Эсвэл үүнийгээ бусдадаа сайн ойлгуулж танилцуулах хэрэгтэй юм болов уу, ард иргэдэд гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Үүрийнтуяа гишүүн асуултаа асууна уу?

**Д.Үүрийнтуяа:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Надад нэг хэд хэдэн асуулт байна.

1 дүгээрт, сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материал худалдаж авах зардал,

2-т нь, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх зардал,

3-д нь, нийгмийн халамжийн сангийн зардлыг 10 хувь буюу эсвэл тодорхой хувиудаар бууруулсан уу? Энэ сургууль, цэцэрлэг, дотуур байрны хоолны материалын зардлыг Сангийн яамнаас хариулах нь зөв болов уу гэж бодож байна. Нийгмийн халамжийн зардлыг Энх-Амгалан сайд, эрүүл мэндийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцтэй холбоотой зардлыг Мөнхсайхан сайд хариулж өгөөч гэж хүсэж байна.

2 дугаарт, Үндэсний аудитын газраас 1 асуулт байна. Энэ төсвийн ерөнхийлөн захирагч нар зөвлөмжид өгсөн, өмнө нь өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, төсвийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгах асуудал энэ жил буурсан болов ч байсаар байна гэсэн л ийм дүгнэлтийг дахин давтагдаад байна гэдэг дүгнэлтийг хийж байна. Хэчнээн ажлууд, хэчнээн төсөл, арга хэмжээ энэ шаардлагыг хангахгүй орж ирээд байгаа юм бэ? Тэгээд үүний жагсаалтыг надад бичгээр өгөөч гэсэн ийм хүсэлт байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ЭМЯ, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам эдгээр зардлууд эдгээр яамдад зардлуудыг хасаж, танаж бууруулснаар энэ Үндэсний аудитын газрын дүгнэлтийн 13-д бичсэн, тусгачихсан байгаа тэр эрсдэл үүсэх үү? Өөрөөр хэлбэл 2025 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмж ямар нэгэн байдлаар буурах, тэгээд тоо хэмжээ нь буурах, хумигдах ийм эрсдэл яамнууд дээр үүсэх үү гэдгийг сайд нараас тодруулмаар байна.

Дараагийн асуудал би Сангийн сайдад Жавхлан сайдад, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан сайдад хандаж, 11 сарын 29-ний өдөр албан бичиг явуулсан. Энэ төсөв хэлэлцэж байгаатай холбоотой нэмэлт мэдээллүүд шаардлагатай байгаа учраас материал хүссэн. Тэгээд энэ албан бичгийн хариуг өнөөдөр өгч туслаач ээ, албан бичгийн хариу ирээгүй байна. Би энэ мэдээллүүдийг энэ төсвийн хэлэлцүүлгийн явцад ашиглах шаардлагатай байгаа учраас анхаарч өгөөч гэж хүсэж байна.

**Л.Энхнасан:** Сангийн яамнаас Санжаадорж дарга хариулах уу. 4 дүгээр микрофоныг өгнө үү.

Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Сургууль, цэцэрлэг болон ер нь зарчмаараа 10 хувиар бол нормативт зардлууд хасагдчихаад байгаа. Тэгэхээр энэ дээр бол 2 төрлийн зүйл хийх шаардлагатай болж байна гэж харагдаад байгаа юм.

1 дүгээрт, тоо хэмжээгээ бууруулах асуудал. Нэг бол тарифаа бууруулах ийм асуудал орж ирэх болчихоод байгаа юм. Өмнө нь Нарантуяа-Нара гишүүн бас асуусан. Хүүхэд хамгааллын зардал, хүүхэд хамгааллын тариф буурч орж ирчхээд байгаа.

Хоолны зардлын хувьд бол яах вэ, давуу тал нь юу вэ гэхээр хоолны зардлыг бид нар ирэх жилд 25 онд нэмэгдүүлнэ гэж тооцож уул нь орж ирсэн юм. Тэгэхээр тэр нэмэгдүүлнэ гэж зорьж байсан зорилтоосоо 10 хувиар бууруулаад явчихна. Тэгэхээр одоогийн авч байгаа хоолны норматив, илчлэг, энэ хэмжээ бол түүхий эдийн зардал дээр буурахгүй гэж бол ойлгогдож болохоор байна.

Харин томилолтын зардал дээр ч байдаг юм уу, тийм ээ, нэлээд өндрөөр дотоод томилолт буурчихсан байгаа зардал дээр нэг бол тоо хэмжээгээ хасуулна, нэг бол ингэнэ гэдэг ийм л маневрын асуудал болж ирчхээд байна. Хугацааны хувьд Сангийн яам бол 5 хоногийн дотор төсвийг дахин боловсруулаад өргөн барьсан. Үндсэн өргөн барьсан агуулга, үзэл санаа нь бол хамгийн том урьдаа барьсан нь өрхийн асуудалтай холбоотойгоор алдагдалгүй төсөв гэдэг зорилт руу дэвшүүлсэн.

Нөгөө талдаа бол 2025 оны баталсан төсөв өөрөө Улсын Их Хурлын зорилго зорилт, чиглэл, агуулга бол тэндээ хадгалагдаж байна гэж үзсэн учраас энэ төсөв дээрээс бол бид нар шууд бууралт хийгээд ингээд орж ирсэн байгаа. Тийм. Салбарууд доголдох асуудлыг бол салбарын сайд нараас илүү тодорхой асуух нь зөв байх аа.

**Л.Энхнасан:** Салбарын сайдаас Энх-Амгалан сайд түрүүлээд хариулах уу?

**Л.Энх-Амгалан:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас үндсэндээ 25 оны анхны батлагдсан дүнгээр бол 4,6 их наядын төсөв батлагдаад, тэгээд сая Ерөнхийлөгчийн хориг тавигдсаны дараа шинээр өргөн барьсан дээр бол бид нар 4,5 их наядар төсвөө өргөн барьсан. Өнгөрсөн юу түрүүн батлагдсан төсвөөс бол нийт 64 тэрбум төгрөг, тэгээд нийгмийн хамгааллын газар 64 тэрбум төгрөгийн төсөв хасагдсан байна гэсэн үг. Энэ дотроосоо бол яах вэ, нийгмийн халамжийн санг та тодотгож асуугаад байх шиг байна. Нийгмийн халамжийн сангийн зарлагыг 1,2 хувь буюу 31 тэрбум төгрөгөөр бууруулж, 2,5 их наядар өргөн мэдүүлсэн байгаа. Гэхдээ тус сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр, тийм ээ, хүүхдийн мөнгө, асаргааны тэтгэмж, амьжиргаа дэмжих мөнгөн зардлууд дээр бол 1 ч төгрөг хасаагүй. Бусад төсөл, хөтөлбөрүүдээс бол үндсэндээ бол тус сангаас нэг 31 тэрбум төгрөг ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Эрүүл мэндийн сайд хариулах уу? Мөнхсайхан сайд.



**Т.Мөнхсайхан:** Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхтэй холбоотой ирэх оны төсөвт 2,9 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байсан. Үүнээс нэг 10 хувийн зарчмаар хасагдаад 300 сая төгрөг хасагдаад, 2,6 тэрбум болсон. Энэ оны төсвийн хувьд бол энэ эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх зардал маань зарцуулах шаардлага үүсээгүй учраас зарцуулалт хийгдээгүй.

**Л.Энхнасан:** Нөгөө тооттой холбоотой, тийм ээ, аудиттай холбоотой, ажлын хэсэг 2 дугаар микрофон.

Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 8 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан төсвийн төсөлд тусгагдсан шинээр эхлүүлэхээр төсөвлөсөн 18 төсөл, арга хэмжээ, магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй байсныг 539,4 тэрбум төгрөгийн 170,7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 14 төсөл, арга хэмжээг бол аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу Сангийн яам хасаж, төсвийг өргөн барьсан. Харин төсвийн ерөнхийлөн захирагчдын өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, магадлалаар баталгаажсан зураг, төсөлгүй 177,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 99,2 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд дахин төсөвлөгдөж ирсэн байгаа. Энэ судалгаа нь бэлэн байгаа учраас танд судалгааг нэр төрлөөр нь хүргүүлж байгаа юм.

**Л.Энхнасан:** Тодруулга.

**Д.Үүрийнтуяа:** 2 сайдаас би юугаа тодруулчихмаар байх юм. Нөгөө аудитын дүгнэлт дээр 13 дээр хэлээд байна шүү дээ, энэ 25 оны төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахад эрсдэл үүсэх юм биш биз дээ гээд. Энэ дээр тодорхой хариулт өгөөч, 1.

2 дугаарт, Сангийн яам хоолны материалын зардлыг хэдэн хувиар нэмэгдүүлж тооцсон юм, энэ жил. Тэгээд хэдээс нь энэ 10 хувийг хасаад одоо нэгж дээрээ 4300, 4900 байсан, хэд болж байгаа юм бэ? Нийгмийн хамгааллын зардал тэр 1,3 хувиар бууруулах ЭМЯ-ны эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх зардлыг 10 хувиар бууруулах асуудал дээр бол яамнууд хүлээн зөвшөөрч байгаа юм байна. Ямар нэгэн асуудал байхгүй гэж үзэж байгаа юм байна гэж ойлгож болох уу?

**Л.Энхнасан:** Энх-Амгалан сайдын асуултад хариулна уу?

**Л.Энх-Амгалан:** Үгүй ээ, одоо тэгээд Их Хурлын гишүүд маань та нар зардлаа бууруул, бүсээ чангал гэж хэлээд бид нар ямар ч байсан зардлаа бууруулъя, бүсээ чангалъя гээд оруулж ирэхээр энэ зардлууд чинь яах юм, тэр зардлууд чинь яах юм гээд асуухад би сайн ойлгохгүй юм. Яах вэ, би та нарын санаа зовж байгааг ойлгож байна. Мэдээж эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбараас бол аль болохоор 1 ч төгрөг хасуулахгүй байх зарчмыг барьж байгаа нь үнэн. Гэлээ гэхдээ нийтээрээ ингээд нийт чинь энэ улсын төсвөөс чинь бараг үндсэндээ 2,4 их наядын ийм том төсвийн таналтууд явж байгаа учраас зарим зүйл дээр ингээд төсвөө таная, бүсээ чангалъя л гэсэн ийм байдлаар л хандаж байгаа шүү дээ. Тийм, тэгэхдээ яг үйл ажиллагаа нэг их тийм айхтар доголдоод уначихгүй болов уу гэсэн ийм л төсөөллүүдийг хийж танилцуулж байна. Их Хурал дээр.

**Л.Энхнасан:** Мөнхсайхан сайд хариулна.

**Т.Мөнхсайхан:** Тийм. Ер нь яг Энх-Амгалан сайдтай л ижилхэн байр суурьтай байна даа.

**Л.Энхнасан:** Хүүхдийн хоолтой холбоотой яг тодорхой гишүүд хэлээд өгнө үү? Санжаадорж 4 дүгээр микрофон хариулна уу?

Санжаадорж Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн хоолны зардал дээр бол 2 төрлийн хоол байгаа.

1 дүгээрт, цэцэрлэг, СӨБ-ын хоолны зардал байгаа. Одоо мөрдөгдөж байгаа тариф бол үндсэн бүлэг дээр бол 3000 төгрөг байгаа. Үүнийг 2025 оны төсвийн төсөлд бол 4000 болгох гээд 1000 төгрөгөөр нэмэгдүүлэх гэж уул нь тооцсон юм. Тэгэхээр нөгөө 900 болно гэсэн үг.

Нөгөө талдаа бол яах вэ, зүгээр бид бас тодорхой хэмжээнд бол эцэг эхчүүдийг үүрэгжүүлэх асуудлыг бол бид дэмжиж байгаа. Энэ агуулгаар бол илүү энэ түүхий эдийн зардлаа нэмэгдүүлэх, ингэснээрээ хүүхдэд шим тэжээлтэй юу өгөхийг бол бид нэмж байгаа.

Үдийн хоол гэж байгаа, 1-5 дугаар ангид, ЕБС-д өгч байгаа. Энэ бол одоо байгаа нь бол 1-5 дугаар анги дээр 1500 төгрөг, тусгай сургуулийн 1-5 дээр 2400 байгаа. Үүнийг мөн адил 1000 орчим төгрөгөөр нэмэгдүүлэхээр бол энэ тооцож байсан.

**Л.Энхнасан:** Тодруулга 1 минут.

**Д.Үүрийнтуяа:** Яах вэ, бид нар энэ Байнгын хорооны гишүүний хувьд тэгээд яг Монголын ард түмний амьдрал ахуй, бүх зүйлтэй холбоотой эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн асуудлууд гол ноён нуруу болж орж ирж байгаа учраас санаа зовоод, амьхандаа энэ яамнууддаа нэг дэмжлэг үзүүлэх санаатай л асуугаад байгаа юм. Түүнээс одоо болж байна гэвэл хамаа алга. Сайн л биз. Ажлын хэсэгтэйгээ санал нэгдээд л Засгийн газартайгаа нэгдээд л явж байгаа бол асуудал алга. Гэхдээ бид нар энэ хүүхдийн хоолны мөнгө дээр бол бодох ёстой юм. Өнөөдөр ёстой хүүхдүүд дуугарч чадахгүйдээ л байж байгаа шүү. Яг үнэндээ. Материалын зардал бид нар та нар сургуулийн тэр дотуур байрыг бод доо. Өдрийн 3 хоол, 2 унд, 4000 төгрөг шүү. Ийм мөнгөөр 4000 төгрөгөөр өнөөдөр ер нь юу авч идэх вэ? Хэдий материалын үнэ ч гэлээ гэсэн. Гэтэл нөгөө талдаа та нар 4 төсөл, арга хэмжээ 99,2 тэрбум төгрөгийн шаардлага хангаагүй арга хэмжээ байна гээд л аудитын дүгнэлтэд орж ирсэн байгааг бас нэг харьцуул ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Санал байна, тийм ээ. Ариунзаяа гишүүн асуултаа асууна уу.

**А.Ариунзаяа:** Ер нь Үүрийнтуяа гишүүний сая хэлж байгаатай санал нэгдэж байна. Ер нь бид нар яагаад асуулт асуугаад байна вэ гэхээр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийнхээ дагуу, зарчмын зөрөөтэй санал гаргаад, энэ манай Байнгын хороонд харьяалагдаж байгаа сайд нартаа тусалчихъя. Энэ салбар маань битгий унаасай гэдэг үүднээс л санал хэлээд байгаа юм.

Манай Байнгын хороонд 3 сайд харьяалагдаж байна. Эрүүл мэндийн сайд, Соёл спорт, аялал жуулчлалын залуучуудын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд.

Эрүүл мэндийн сайдаас асуух зүйл нэг их алга даа. Ер нь туршлагатай сайд. Тэгээд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраа чадавхжуулаад, жоохон хариуцлагажуулаад явчихвал харьцангуй гайгүй ажлууд нь тэгээд гайгүй болчих байх гэж найдаж байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдаас мөн түүнчлэн асуух юм алга. Үнэндээ энэ 18,3 тэрбум ваучерын асуудлаас болж ер нь бол салбараа нэлээд доош нь татаж унагаалаа даа. Сая орж ирсэн дагаж байгаа хуулиуд дээр зөвхөн энэ ваучерын асуудал ч биш Соёл урлагийг дэмжих сан, Кино үйлдвэрлэлийг дэмжих сан тэр чигтээ татан буулгах санал орсонд эгдүүцэж, энэ хуулиудыг хэлэлцэхгүй гэдэгт гишүүд саналаа өгсөн. Энэ нь бол 18,3 тэрбум төгрөгийн ваучерыг эргүүлээд тавьчихаж байгаа асуудал огтоос биш. Соёл урлагийн салбарыг ийм хэмжээнд нь унагах гэж байгаа бол төсвөөсөө гадна, тусдаа хууль тогтоомжийн тухай хуулийнхаа дагуу олон нийтийн саналаа аваад, мэргэжлийн хүмүүсийнхээ саналыг аваад, тусад нь энэ асуудлаа хэлэлцсэн нь зүйтэй байх гэдэг үүднээс энэ хуулиудыг хэлэлцэхгүй гэж буцаасан болно.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асуух 1 зүйл нь өөрөө юу юм бэ гэхээр яг энэ хүүхэд хамгааллын зардалтай холбоотой бүхий л салбаруудыг салбар харгалзахгүйгээр энэ зардлуудыг 100 хувь зарим зардлыг бууруулж байгаад бол яг энэ хүүхэд хамгааллын зардал дээр нэн ялангуяа асуудлууд үүсэх вий дээ. Энэ хорооны урамшуулал гээд байгаа юм. Үндэсний хорооны урамшуулал. Салбарын яамны сайдын урамшуулал, газрын даргын урамшуулыг хасаж болно.

Сум, орон нутагт байгаа хамтарсан багийн урамшуулал, хөгжлийн бэрхшээлийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож байгаа энэ комиссын урамшуулал, яг жинхэнэ маш их ачаалалтай ажилладаг тэр анхан шатын хүмүүст жоохон цагаа илүү гаргаадахаач, энэ асуудалд анхаараадхаач гээд нэгэнтээ бид нар орон тоо илүү баталж чадахгүй байгаа учраас жоохон урамшуулал тавиад ажиллуулж байгаагийн энэ урамшуулыг хасаж байгаа нь өөрөө эргээд энэ хүүхэд хамгааллын зардал болоод хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох комиссын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх вий. 1 минутаа нэмээд авчихъя дарга аа. Нэгмөсөн асуучихъя.

Нөгөө талдаа Хүүхэд хамгааллын тухай хуулиар сум, хорооны нийгмийн ажилтны орон тоо гаргасан. Энэ шинэ энэ төсвөөрөө хэдий хэмжээндээ тусаж чадсан бол оо, хасагдсан болов уу? Энэ орон тоо байдаггүй учраас бусдаар гүйцэтгүүлэх зардалд яг энэ хүүхэд хамгааллын ажилтны зардлыг тусгадаг. Дахиад хасагдаад ороод ирж, 11,2 тэрбум төгрөг хасагдаад ороод иржээ. Тэгэхээр энэ сум, хорооны нийгмийн ажилтны асуудал хэрхэн яаж тусгагдаад, юу нь хасагдаад, яаж ороод ирэв, энэ нь хүүхэд хамгааллын ажилд хэрхэн яаж нөлөөлөх вэ?

Эцэст нь Хүүхдийн төлөө сангийн асуудал. Хүүхдийн төлөө санг 2017 онд Хүрэлсүх Ерөнхий биш ээ, 2019 онд юм байна. 20 оны Засгийн газар Хүрэлсүх Ерөнхий сайдын үед баталсан. Тухайн үедээ шинэ жилийн үдэш иргэдийн

хандиваар 2, 3 тэрбум төгрөг босож анхны гараа нь бол тэр байсан. Засгийн газраас буюу төсвөөс 1 ч төгрөг тавигдаагүй. Одоо 22 тэрбум төгрөг болчихсон байна. 20 оноос хойш 22 тэрбум төгрөг болсон байна. Энд бол авто тээврийн газрын азын дугаар борлуулсны орлого бол дийлэнхийг нь эзэлж байгаа. 22 тэрбум төгрөгийг яагаад хүртэл зарцуулж чадахгүй байна вэ? 25 онд ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Эхлээд Сангийн сайд, Сангийн яамнаас хариулах уу. 4 дүгээр микрофон Санжаадорж.

Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Тийм, хүүхэд хамгааллын зардлыг бол нөгөө барьсан зарчмынх нь дагуу 10 хувиар бууруулсан байгаа. Гэхдээ энэ нь өмнөх жилээс нэмэгдүүлж тооцсон тэр тарифаасаа буурч ирэхээр тооцсон байгаа. Орон тоотой холбоотой асуудлуудыг бол бид нар хүүхэд хамгааллын зардлыг бол авсан. Ирэх жил бол нэлээд дорвитой ахицууд хүүхэд хамгааллын салбар дээр гарах болов уу гэж бид найдаж байгаа. Төсвийг бол нэлээд нэмэгдүүлсэн, тийм, 24 онтой харьцуулахад.

**Л.Энхнасан:** Энх-Амгалан сайд хариулна. 3 минут.

**Л.Энх-Амгалан:** Ариунзаяа сайдад талархаж байгаа. Манай салбарын сайд байсан хүн. Гол гол хуулиудыг батлуулсан, хуулийнхаа хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг хүлээгээд, Их Хурлын гишүүн болж байгаа. Тийм учраас бол батлуулсан хуулийн хэрэгжилтийг хангах тал дээр ингэж шахаж шаардаж, сэтгэл гаргаж ажиллах нь зүйн хэрэг гэж би би бодож байна. Гэхдээ яах вэ, ямар ч байсан өмнөхөө бодох юм бол бид нар хүүхэд хамгааллын зардлууд бол хасагдсан биш, нэмэгдсэн шүү дээ, нэмэгдсэн. 25 оны төсөв өргөн баригдахад нэмэгдэж өргөн баригдсан. Гэхдээ яах вэ, нөгөө жишгээрээ нэг бусад зардлуудаас 10 хувь гэдгээрээ жишгээрээ хасагдсан учраас тэр бол нэмэгдсэн төсвөөс 10 хувь л хасагдсан гэсэн үг. Жишээ нь хүүхэд, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн хураамжид гэдэг дээр бол үндсэндээ 20 тэрбумаас 2,3 тэрбум төгрөг л хасагдсан гэсэн үг. Гэхдээ өмнөхөөсөө бол энэ чинь хэд дахин нэмэгдсэн 1 дүгээрт төсөв байгаа.

2 дугаарт нь, бол энэ Хүүхэд хамгааллын тухай хуулиар 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлэх энэ хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой нөгөө сумд ажиллах анхан шатан дээр ажиллах хүмүүсийн юу бол 2,7 тэрбум төгрөгөөр буурч, 24,4 тэрбум төгрөг болсон. Гэхдээ энэ чинь ийм шүү дээ. Яг хууль хэрэгжүүлээд эхлэхээр бид нар чинь 1 сарын 1-нээс хэрэгжинэ, эд нарыг чинь бэлтгэл ажлуудыг нь хангана, 1 дүгээрт.

2 дугаарт бол би яг 900 хэдэн хүнийг нэг дор ингээд аваад, ингээд тэр зохион байгуулаад тэр ажилд оруулна гэдэг бол 1 жилийн ажил бас би биш гэж бодож байгаа шүү дээ. 1 дүгээрт, хүний нөөцийн асуудал байна. 2 дугаарт, ингээд энэ чинь нэлээн улс орон даяар шууд нэг амьсгаагаар хэрэгжүүлэх биш, тодорхой хэмжээнд үйл ажиллагаагаа өргөтгөх ийм хэлбэрээр бид нар ер нь зөв зохион байгуулах нь зүйтэй болов уу гэж би бодож байгаа. Хүмүүсээ бид нар бэлтгэх ёстой. Тэр кейс менежмент энэ тэр гээд яг энэ, яг тэр нөгөө анхан шатан дээр ажиллах гэж байгаа хүмүүс дээр тодорхой ур чадварууд нэлээн шаардагдах юм байна. Ур чадварын сургалтуудыг бид нар зохион байгуулагдах ёстой.

Нөгөө талаасаа энэ хүүхэд хамгааллын асуудал бол ганцхан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал биш. Би энэ Боловсролын сайд байхдаа энэ чиглэлээр нэлээн анхаарч, сургуулиуд дээр сэтгэл зүйч нарыг, одоо төрийн өмчийн бүх сургуулиуд сэтгэл зүйчтэй болсон. Нийгмийн ажилтнууд нь тодорхой ажил үүргийн чиг үүргүүд нь тодорхой болсон. Нэг хүүхдийг сургадаг хувьсах зардал дээр нь тодорхой зардлууд тавьж өгдөг болсон. Тийм учраас хүүхэд хамгааллын асуудал дээр бол илүү Боловсрол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүйн яам, Соёлын яамнуудын хамтарсан ийм салбар дундын зохицуулалтуудыг бид нар хийж байж энэ дээр тодорхой үр дүнгүүд гарна л гэж би харж байгаа юм.

Тэгээд юм болонгуут нөгөө баруун талын хар овоохой гэдэг шиг бүх юмыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу чихчхэж байж ер нь болохгүй л дээ. Бусад салбаруудын нэг ганц нэг тийм муу жишгүүд харагдсан. Тэгэхдээ энэ дээр бол ямар ч байсан 25 он дээр бол энэ хүүхэд хамгааллын асуудал дээр нэлээн ахиц дэвшил гарсан жил байх болов уу гэж бодож байна.

**Л.Энхнасан:** 2 минут тодруулгаа шууд авчихъя.

**А.Ариунзаяа:** Энх-Амгалан сайдаас би юу гэж ойлгов гэхээр Байнгын хорооны гишүүд нэг их айхтар зарчмын зөрөөтэй санал гаргаад байх шаардлагагүй юм байна. Бүх юм сайхан юм байна гэж ойлголоо. Хамтарсан баг болоод хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ тогтоодог комиссын урамшууллыг хассаныг бол та гайгүй болчих юм байна гэж ойлгочих шиг боллоо. Зөв үү.

2 дахь нь болохоор яг энэ Хүүхдийн төлөө сангийн 22 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаар би дахиад лавлаад байна. 22 тэрбум төгрөг бол улсын төсвөөс орсон 1 ч төгрөг байхгүй. Хүний юмыг хүнээс нь өөрөөс нь харамлаад байх юм. 8 тэрбум төгрөг яг юунд тавьсан бэ? Үлдсэн 14 тэрбум төгрөг нь яагаад Төрийн сан дээр ямар ч хүү бодогдохгүй ингээд хадгалагдах болчихов оо? Үгүй ядаж энэ ангиудад энэ утаа агаар шүүгч гэх мэтчилэн ийм хөрөнгө оруулалтуудыг хийж болдоггүй юм уу? Энэ хүүхдийн төлөө сан ийм ашиглалтгүй байх юм бол энэ сан татан буугдах тал руугаа явах гээд байна уу, яах гээд байна вэ?

**Л.Энхнасан:** Энх-Амгалан сайд хариулна.

**Л.Энх-Амгалан:** Ариунзаяа сайд аа, жаахан төрийн ой санамжтай байх ёстой шүү, тийм ээ. Өөрөө ямар сан байгуулчхаад, ямар журам батлуулчхаад ингээд явсан гэдгээ санах хэрэгтэй. Ямар ч юм хийхээргүй тийм чөдөр тушаа болчихсон л журамтай байсан юм байна лээ шүү дээ. Юу ч шийдэж чадахгүй, хэдэн олимпиадад олон улсын уралдаанд оролцсон хүүхдүүдийн л юуг өгдөг байсан болохоос өөр тэр журмаар чинь юу ч хийж чадахгүй байсан шүү дээ. Одоо сая энэ журмууд чинь сая л өөрчлөлтөд орж, Засгийн газруудаар батлагдаж одоо л амилж байна шүү дээ. Наад журам чинь. Жаахан ой санамжтай бай л даа, тийм ээ. Одоо шинэ журам чинь сая Засгийн газраар батлагдлаа. Одоо журам нь өнгөрсөн 7 хоногт албажиж байна. Шинэ журмын дагуу бид нар 1 сарын 1-нээс энэ дээр хөрөнгө оруулалтын асуудлууд шийдэх гэж байна. Өөр яах юм, хууль журмын хувьд хэмжээнд л арга хэмжээ авч явах ёстой биз дээ. Тэр юунд зарлахыг би мэдэхгүй. Шинэ батлагдсан журмын дагуу өнөөдөр бүх сонгон шалгаруулалтыг хийж байж хөрөнгө оруулалтад зарцуулна.

**Л.Энхнасан:** Сангийн яамнаас Санжаадорж байхгүй байна. Хэн хариулах вэ. Юу дэгээ бариад яриарай. Микрофонгүй, зүгээр байраасаа яриад хэрэггүй шүү.

Сангийн яам. Ажлын хэсгээс Сангийн яам хэн байна? Албан тушаалаа хэлээд яриарай, 5 дугаар. 4 дүгээр микрофон.

Сайн байцгаана уу.

**Л.Энхнасан:** Юу гишүүд, тайван. Сангийн яам 4 дүгээр микрофон хариулна уу.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ихтамир гэж хүн байна. Ариунзаяа сайдын асуултад хариулъя. Хүүхдийн төлөө сан маань Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу 2021 оноос хойш энэ сан ажиллаж байгаа. Үндсэн эх үүсвэр нь бол улсын төсөв, хандив, тусламж, автомашины сонирхол татахуйц улсын дугаар худалдан борлуулсны орлого, хүүхдүүдэд чиглэсэн урлаг соёлын арга хэмжээний орлого зэргээс санхүүжилт нь бүрддэг. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиараа 3 үндсэн зориулалтаар л зарцуулагдахаар хуульчлагдсан.

1-д нь бол, хүүхдийн хөгжлийг дэмжихтэй холбоотой бүтээн байгуулалтыг дэмжсэн төсөл хөтөлбөрт.

2 дахь нь, тив дэлхийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдэд урамшуулал олгох. Мөн энэ тэмцээнд оролцсон болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд мөн урамшуулал ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Ажлын хэсэг нэмээд хариулна уу. 4 дүгээр микрофон.

**Т.Ихтамир:** Одоо тэгээд сан бол Хүүхдийн төлөө сангаас санхүүжилтээс энэ 3-аас бол эхний 1-д дурдсан хүүхдийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалт 1 ч төсөл хөтөлбөр одоогоор санхүүжилт аваагүй. Учир нь 2021 онд батлагдсан ийм журмын хүрээнд ирүүлсэн төсөл шалгарсан 1 л төсөл байдаг. Энэ нь Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дээр хүүхдийн замын танин мэдэхүйн шинжтэй энэ талбай байгуулах. Энэ нь өөрөө ажлын гүйцэтгэл нь даалгавар нь төсөвт өртөгтөө багтахгүй гэсэн үндсэн шалтгаанаар 3, 4 удаа тендер зарлаад ийм байдалтай байна. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг захиран зарцуулах, түүнд хяналт тавих журам бол түрүүн манай сайд хэллээ. Засгийн газрын тогтоолоор энд өөрчлөлт ороод ингээд албажаад явж байгаа. Энэ журмаараа бол он гараад эхний улиралд бол төсөл, хөтөлбөрүүдийг хүлээн авах ийм чиглэлтэй ийм журам батлагдсан.

Дээр нь энэ хуучин журмаар бол 15 гишүүнтэй буюу яам, холбогдох байгууллагуудын төлөөлөл орсон 15 ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Тэгэхээр шинэ журмаараа бол захиран зарцуулагдана гэж ойлгож болох уу, тийм ээ, сайд аа.

Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Би хоцорч орж ирсэн. Тийм учраас ороогүй байсан юм. Ер нь тэгээд цалин хөлсний бодлого бас Нийгмийн бодлогын байнгын

хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгаа учраас би уялдуулж асууж байгаа юм. Миний асуух гэж байгаа зүйл мэдээж салбар хоорондын болоод нэлээн томоохон зарчмын асуудал гэдгийг би зүгээр хувьдаа бодож байгаа юм. Энэ Сангийн яам байх уу, хэн Энх-Амгалан сайд хариулах юм болов уу, хэн нь хариулах юм бол оо? Энэ нэг сайд нарын дэргэд Үндэсний хороо, Төв комисс, зөвлөл нэршлийн хувьд бол бүр янз янзаараа байгаа. Ийм хуулиар байгуулагдсанаас бусад ийм зөвлөл, хороо хэчнээн байна. Энд хэчнээн хүн ажиллаж байна. Цалингийн сан дээр хэчнээн төгрөг зарцуулж байна. Мөнгөн дүнгээр хэлж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Өнөөдөр миний зүгээр багцаагаар нэг 50 орчим байна. Үүний цаана юу харагдаж байна гэхээр төрийн чадавхыг улам сулруулж байна. Ерөнхий чиг үүргийн яам гээд салбар хоорондын буюу уялдааг зохицуулах яамны дэргэд хүртэл ийм салбар хороонууд байгуулагдаж байна. Чиглэлийн яамны дэргэд байгуулагдаж байна. Сүүлдээ энэ яамнууд нь ажлаа хийж чадахгүй болоод ийм юм хийгээд байгаа юм болов уу гэж би бодоод байгаа байхгүй юу. Тэгээд жишээ нь бодлого боловсруулж байна гээд байгаа юм. Хурдасгуур төв жишээ нь бид орон сууцны бодлого боловсруулж байна гээд над руу дайрч байгаа юм л даа. Би чуулган дээр зарчим хэлье. Тэгвэл тэр Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын яамаа татан буулгамаар байна. Зарчмын хувьд. Ингэж байж энэ төрийн албыг цомхон, бүтээмжтэй, хэмнэлттэй, хариуцлагаа хүлээдэг сайд нь баймаар юм.

Сүүлд нь энэ орон сууцны бодлого буюу Засгийн газрын үйл ажиллагааны бодлого хэрэгжихгүй болохоор Хурдасгуур төвийн даргаас асуух юм уу. Батсуурь сайдаас би хариуцлага нэхэх юм уу. Улсын Их Хурал чинь. Хэн нь энэ хариуцлага хүлээх гээд ингээд яамнуудын чиг үүрэгтэй зэрэгцүүлээд ингээд Үндэсний хороо энэ тэр байгуулаад байгаа юм бэ гэдэг зүйл цаашаа яригдана. Үүнийгээ хэдүүлээ нэг цэг тавимаар байна. Энэ сүүлдээ Төрийн албаны тухай хуулийн босго давахгүй хүмүүсүүдийг цуглуулдаг ийм зүйл болж хувирлаа. Шинэ сэргэлтийн бодлогын хороо л гэнэ. Бүсчилсэн хөгжлийн гэж байна. Бүсчилсэн хөгжлийн бодлого жишээ нь Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгаа байхгүй юу. Чадахгүй байгаа бол сүүлд тэр Шадар сайдын яамыг Эдийн засгийн хөгжлийн яамыг буулгая л даа. Эдийн засгийн яамыг ингээд байгуулаад энэ бодлого төлөвлөлт явна гэххээд одоо дэргэдээ Төсвийн хууль дагаад дахиад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зөвлөл байгуулна гэж байгаа юм. Боль л доо. Төрийг нэг талаараа бүгд цомхон болгоё, хэмнэлттэй болгоё, бүтээмжтэй болгоё гэххээд нөгөө талдаа ингээд нэг юм ярихаар л орон тоо. Энэ зүйлүүдийг ингээд зогсох цаг болсон.

Тэгээд Нийгмийн бодлогын байнгын хороо энэ дээр анхаармаар байгаа юм. Энэ Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг үнэлээд үнэхээр төрд ур чадвартай хүмүүсийн ажиллах жилээс болоод орж чадахгүй учраас заримдаа нэг ийм зүйл рүү явуулаад байгаа нь үнэн. Тэгэхдээ энэ зүйлүүдийг цэгцлэх цаг болсон.

Тэгээд би нэг зүйлийг зүгээр хэлье. Алтанхуяг гуайн Засгийн газрын үед төрийг цомхон болгох гээд нэлээн сүртэй юм ярингуутаа агентлагуудыг татан буулгаад, төрийн өмчит компаниудыг олноор ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Та нэмж түрүүн асуулт асуусан учраас бол нэмэлт цаг байхгүй. Хамрагдах салбарын хүрээний дагуу Үндэсний зөвлөл хэд байна гэдгийг Сангийн яамнаас хариулах уу, эс үгүй бол 2 яамдын сайд хариулах уу? Сангийн яамнаас Санжаадорж дарга хариулна. 5 дугаар микрофоныг нээнэ үү.

Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Одоогоор бол Үндэсний хороо, зөвлөл, комисстой холбоотойгоор байгуулчихсан байгаа, мөн үйл ажиллагаа зарим нь явдаг, явдаггүй гэх мэт ингээд тооцоод үзэхээр бараг 40 гаруй Үндэсний хороо, зөвлөл байгаа. Яг хуультай гээд үзэх юм бол жишээ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл ч гэдэг юм уу, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл гэдгээс гадна эдгээр байгууллагуудаас гадна бол ихэнх нь бараг 80 орчим хувь нь яг ийм байгууллагууд байгаад байгаа.

Засгийн газрын тухай хуулиар бол Засгийн газарт юуг, чиг үүргүүдийг бол хуваарилчихсан байдаг. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд төсвүүд хуваагдаад явчхаж байгаа гэсэн үг. Тэгээд энэ чиг үүргийнхээ хүрээнд бол бид нар Сангийн яамны хувьд бол аль болох цомхон байлгах, шинэ Үндэсний хороо байгуулахгүй байх гэдэг дээр санал өгөөд явдаг байгаа. Одоо бол яг өнөөдрийн байдлаар хэчнээн орон тоо, хэчнээн төгрөгийн цалин байгааг тооцож үзэж байж, танд мэдээлэл өгөхгүй бол шууд хэлэх боломжгүй байна.

**Л.Энхнасан:** Асуулт асууж, хариулт авч дууслаа.

1 минут тодруулах.

**П.Сайнзориг:** Би ингээд үгээ гүйцээчихье. Тэгээд Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж ингэж Үндэсний хороо, комисс байгуулахыг больё. Төрийн хэмнэлтийн хуулиар тухайн чиг үүргийг ямар нэгэн нэршил болон хэлбэрийг нь өөрчилж, дахиж байгуулахыг хориглож байгаа шүү дээ. Тэгээд энэ чинь чиг үүргийн давхцал болж байгаа байхгүй юу. Яамнуудтай зэрэгцээд статус нь ямар хариуцлага хүлээх юм уу, үгүй юу гэдэг нь ойлгомжгүй ийм үндэсний зөвлөл, хороо байгуулж байгаа нь татан зогсооё гэдэг зүйлийг хэлье.

Тэгээд би түрүүн хэлж байсан. Алтанхуяг гуайн Засгийн газрын үед энэ агентлагуудыг татан буулгаад, төрийн өмчит компани байгуулаад усны агентлагийн бүх мэдээллүүдийг Монгол Улс концернд өгч шилжүүлсэн юм. Бүх датанууд нь алга болсон. Төрд байсан энэ онц чухал мэдээллүүдийг хүртэл компанид өгөөд, энэ мэдээллүүд нь сүүлд нь хожим нь алга болж байгаа байхгүй юу. Ийм байдлаар ингэж төрийг хүчгүйдүүлдэг, төрийг бүтээмжгүй болгодог, төрийн чиг үүргийн давхцалыг бий болгодог, Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж байгаа хуультайгаас бусад энэ Үндэсний хороо, Төв юу гэж нэрлэдэг юм, эд нарыг татан буулгах ажлыг зайлшгүй хиймээр байна. Үүнийг анхаараач гэдэг зүйлийг л хэлмээр байна.

**Л.Энхнасан:** Санал тийм ээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? Одоогоор 2 санал ирсэн байна. Үүрийнтуяа гишүүн юугаа, томъёололтой хуудсаа, байна уу?

3 саналын томъёололтой санал байна.



1 дүгээрх нь Амарсайхан сайдаас ирсэн санал байна. Төслийн 2 дугаар хавсралтын 21.1.8-д Налайх, дулааны шинэ эх үүсвэр 216 мвт-ын эхний ээлжийн ажил төсөвт өртөгт 56 тэрбум, 2025 онд санхүүжүүлэх дүнг 16,906 тэрбум гэснийг нийслэлийн Налайх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга шинээр барих зориулалтаар болгон өөрчилж, Эрүүл мэндийн сайдын багцад шилжүүлэн шинээр тусгах гэсэн санал байна. Энэ дээр сайд, Мөнхсайхан сайд тайлбар хэлэх үү. Санал гаргасан гишүүн Амарсайхан сайд байна. Шадар сайд. Мөнхсайхан сайд тайлбараа хэлнэ үү?

**Т.Мөнхсайхан:** Тийм. Налайх дүүрэгт барих гэж байсан станцыг эрүүл мэндийн салбар луу эмнэлэг барихад ийм шилжүүлэх хүсэлтэй байгаа юм байна лээ. Тэгээд Налайх дүүрэгт бол шинэ эмнэлэг барьж байгуулж болно. Гэхдээ цаашдын үйл ажиллагааг нь хэрхэн яаж хангах вэ? Энэ эмнэлэг ялангуяа гүйцэтгэлийн санхүүжилттэй болсон энэ үед эмнэлэг маань өөрийгөө авч явах энэ чадвар, чадавхыг нь сайн тооцоолж байж, барих нь зүйтэй гэж үзэж байгаа. Ер нь бол эмнэлгийн барилга нь бол хуучирч муудсан, шинэчлэх тал дээр бол зөв гэж харж байгаа. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Энэ Сангийн яамнаас тодруулъя. Энэ зураг төсөлтэй байгаа юм болов уу, энэ ер нь Сангийн яамтай үүнийгээ ярилцсан уу. Яах вэ, мэдээж бид нар бол салбарын хүмүүс эмнэлэг барихад дэмжих нь дэмжинэ л дээ. Тэгээд энэ дээр Сангийн яам нэг хариулна уу.

Сангийн яам Санжаадорж. Энэ эмнэлэг бол зураг, бид нартай ярилцсан зүйл байхгүй, зураг байхгүй гэж бид ойлгож байгаа. Тийм. Тэгэхээр нөгөө төсвийн шаардлага бол хангахгүй л юм байна лээ дээ.

**Л.Энхнасан:** Яах вэ, санал хураагаад л явъя, тийм ээ. Зарчмын зөрөөтэй санал ирсэн учраас тийм. 1 яамны багцаас, нөгөө, 1 сайдын багцаас нөгөө сайдын багц руу л шилжүүлэх гэж байна л гэж ойлгож байна шүү дээ, тийм ээ. Тийм, ер нь тэгээд яах вэ саналаа хураагаад явчихъя. Ажлын хэсэг дээр илүү тодорхой ярьсан нь зүйтэй байх л даа. Нэгэнт зарчмын зөрөөтэй санал томъёолол энд ирсэн учраас саналыг нь хураагаад явчихъя. Дэмжихээр санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явна.

37,5 хувиар дэмжигдсэнгүй. Орсонгүй. Тэгвэл саяын санал хураалтыг хүчингүйд тооцох уу? Тийм. өөрсдөө саналаа, горимын саналаа. Үүрийнтуяа гишүүн горимын санал гаргана.

**Д.Үүрийнтуяа:** 8 болж байна, тийм ээ, ямар ч байсан протоколд тэмдэглүүлье. Дэмжсэн санал өгсөн байна, орсонгүй.

**Л.Энхнасан:** Протоколд, дэмжье. Үүрийнтуяа Сарнай гишүүн 2 дэмжсэнээр санал. Тэгэхдээ санал дэмжигдсэнгүй.

“Төрийн албан хаагчийн цалинг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 6 хувиар нэмэгдүүлэх” гэснийг “гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх дараах мега төслийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. Үүнд: Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн УЦС барих төсөл, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх төсөл, Улаанбаатар хотын төвийн дулаан хангамжийн төсөл, Улаанбаатар хотын ногоон орон сууцжуулалтын төсөл гээд 219 тэрбум

төгрөгийн дүн байна. Санал гаргасан Сайнзориг гишүүн. Сайнзориг гишүүн саналаа тайлбарлана уу.

**П.Сайнзориг:** Засгийн газраас бол төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой үе шаттайгаар нэмэгдүүлээд явж байгаа. Сая л гэхэд энэ 24 оны 4 сарын 1-нээс нэмэгдүүлсэн. Тэгээд энэ удаад нэмэгдлийг 1 сарын 1-нээс байгааг 6 сарын 1 болгож хойшлуулаад, үүнээс гарах хэмнэлтийн зардлыг томоохон мега төслүүдийн санхүүжилтийг санхүүжүүлэе л гэдэг л ийм товчхон санал байж байгаа. Ингэж байж цаашдаа энэ томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг цаг хугацаандаа ашиглалтад оруулж, үүнээс бид нар экспортыг дэмжих импортыг орлох тийм ээ, эргээд энэ эдийн засгийг тэлэх суурь дэд бүтцүүдээ л сайжруулж явахгүй бол нэг цалин тавьдаг, халамж тавьдаг. Энэ байдлаараа олон жил явж чадахгүй. Уул уурхайн цикл унахад халамжаа ч тавьж чадахгүй, цалингаа ч тавьж чадахгүй нөхцөл рүү орчих гээд байна.

Тийм учраас үүнийг Нийгмийн бодлогын байнгын хороо цалин хөлсний бодлогыг барьж байгаагийн хувьд би энд хураалгая гэж бодож байгаа юм. Тэгээд гишүүдийг дэмжиж өгөхийг хүсье.

**Л.Энхнасан:** Үг хэлэхгүй. Сангийн яамнаас тайлбар. Ажлын хэсгээс тайлбар. Энэ дээр тайлбар тавих, ажлын хэсгээс хэн тайлбар тавих вэ? Хураалгачихъя тэгвэл.

Төрийн албан хаагчийн цалинг тийм, 6 хувиар нэмэгдүүлэхийн оронд гадаад зээл тусламжийг хэрэгжүүлэх дараах мега төслийг санхүүжилтийг нэмэгдүүлэе гэсэн томьёоллоор дэмжихээр санал хураалт хийе.

100 хувиар татгалзлаа.

Үүрийнтуяа гишүүн саналаа бичгээр өгөөрэй, тийм ээ.

**Д.Үүрийнтуяа:** Сая бас асуусан асуулттай холбоотойгоор зарчмын зөрөөтэй санал гаргах шаардлагатай юм байна гэж үзээд ингээд нөгөө тусгай яаралтай горимоор хэлэлцэж байгаа учраас саналаа шууд гаргаад бичгээр хүргүүлэе. Үндэсний аудитын газар дээр өгсөн тэр дахин зураг төсөв, магадлалгүй орж ирсэн 4 ажлын 1 нь энэ НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх суурь конвенцын талуудын 17 дугаар Бага хурлын хурлын байгууламж гэж байгаа. 50 тэрбум төгрөг тавьчихсан байгаа. Ямар ч зураг төсөв, магадлал байхгүй. Ингээд барилга байгууламж 1 удаагийн хуралд зориулж барихад 50 төгрөг тэрбум төгрөг зарцуулж байхаар үүнийгээ тэр сургууль, цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны материал худалдаж авах зардал хассан 10 хувийг хассан, 31,4 тэрбум төгрөгийг эндээс санхүүжүүлэх ийм зарчмын зөрөөтэй саналыг гаргаж байна.

Зөрөө 8,6 тэрбум төгрөгийн үлдэж байгаа, 50 тэрбум дээр. Зураг төсөв, магадлал бүх ажил нь хийгдчихсэн хэр нь төсөвт орж чадахгүй байгаа олон асуудлын 1 нь манай Эрдэнэт хотын эрчим хүчний найдвартай байдлын асуудал. Захын гэр хорооллууд, ААН-үүд хүчдэлийн уналттай, плитка зурагтаа хамт залгаж чаддаггүй ийм нөхцөл байдалд өнөөдөр Монгол Улсын 2 дахь том хот амьдарч байгаа. Энэ нийтдээ төсөвт өртөг нь 33,3 тэрбум төгрөгийн өртөгтэй юм.

Тийм учраас эхний санхүүжилт болох 8,6 тэрбум төгрөгийг эндээс санхүүжүүлэх ийм 2 эх үүсвэрийг энэ 50 тэрбумаас гаргах зарчмын зөрөөтэй саналыг оруулж байна.

Эрчим хүчний асуудал учраас Эдийн засгийн яам юун дээр л гаргана л даа, ЭХЯ дээр. Эдийн засгийн байнгын хороо болон Төсвийн байнгын хороон дээр давхар яригдах байх. Энэ удаад бол хэрвээ тэр асуудлыг энд хэлэлцэхгүй гэвэл 31,4 тэрбум хүүхдийн хоолны зардлын асуудлыг оруулчихъя. Бусад асуудлыг нь би холбогдох Байнгын хороодод нь гаргачхаж болж байна.

**Л.Энхнасан:** Ажлын хэсэг дээр байхгүй байгаа юм уу, тийм ээ. Сангийн яам тайлбар өгнө үү? 7 дугаар микрофон. Албан тушаалаа хэлээрэй.

Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал.

СОР-ын 17 дугаар хурлыг 2026 онд Монгол Улс зохион байгуулах үүрэг хүлээсэн байгаа. Тэгэхээр энэ 50 тэрбумын хувьд бол яг барилга барих биш угсардаг байгууламжийг энэ богино хугацаанд авчирч, байгууламж байдлаар Хөшгийн хөндийд байрлуулаад, дараа нь энэ байгууламжийг бусад зориулалтаар ашиглах ийм төлөвлөлтөөр энэ төсөл тусгагдсан. Хэрвээ энэ зардал хасагдвал СОР 17-г Монгол Улс зохион байгуулах боломжгүй болно. Энэ бол олон улсын хүрээнд үүрэг хүлээсэн ийм олон улсын арга хэмжээ байгаа учраас энэ зардлыг хасагдуулах нь буруу гэж үзэж байна.

**Л.Энхнасан:** Үүрийнтуяа, микрофоныг өгнө үү. 1 минут.

**Д.Үүрийнтуяа:** 50 тэрбумын асуудал өнөөдөр анх хөндөгдөөгүй шүү дээ. Төсвийн анхны хэлэлцүүлэг хийгдэхээс өмнө 2 сарын өмнөөс яригдаж эхэлсэн. Энэ арга хэмжээг хийж болно. Гэхдээ энэ чинь барилга байгууламж гээд би Үндэсний аудитын газрын дүгнэлтийг үндэслэж би ярьж байгаа. Үндэсний аудитын газар зураг төсөв байхгүй, хууль зөрчиж орж ирсэн 4 төсөл, арга хэмжээ байна гэсний 1 нь. Хэрвээ тэр үнэхээр зураг төсөв шаардлагагүй байсан юм бол яагаад аудитын дүгнэлт гаргаж байгаа юм. Аудитад та бүхэн танилцуулахдаа яагаад тэрийгээ хамгаалж чадаагүй юм.

Тэгээд зураг төсөв байхгүй арга хэмжээг улсын төсөвт тусгахыг хориглодог биз дээ. Бид нар бусад бүх аймгуудын асуудлыг, бусад бүх яамдын асуудлыг зураг төсөвгүй ажил гээд хасдаг шүү дээ. Тэгээд ямар нь хасагдаад ямар нь үлдэх ёстой юм. Энэ олон улсын хурал зохион байгуулагдах ёстойг ойлгож байгаа. Тэгээд барилга байгууламжгүй болохоор зохион байгуулагдах боломжгүй болчих юм уу. Энэ чинь барилга байгууламжийн зардал л гэж байгаа шүү дээ.

**Л.Энхнасан:** Тэгэхээр Үүрийнтуяа гишүүний гаргасан зарчмын зөрөөтэй саналын нэр томъёог танилцуулъя.

Нэгдсэн үндэстний байгууллагын цөлжилттэй тэмцэх тухай суурь конвенцын талын 17 дугаар Бага хурлын байгууламжийн төсвийг 31,4 тэрбумаар бууруулж, цэцэрлэг, сургууль, дотуур байр, хоолны материал худалдан авах зардлыг 31,4-өөр нэмэхээр зарчмын зөрөөтэй. Үүнийг дэмжихээр, томъёоллоор санал хураалт явуулъя.

25 хувиар дэмжигдсэнгүй.

Ер нь тэгэхдээ 1 сайдын багцаас нөгөө сайдын багц руу шилжүүлэх нь зарчмын хувьд буруу байх аа, тийм ээ.

Ингээд Зулпхар гишүүний зарчмын зөрөөтэй 3 санал ирсэн байна.

31.4.1.1-ийн шалгуур үзүүлэлт, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд НДШ төсөл иргэн гэснийг Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо гэж тоо гэж, 2025 оны зорилго түвшнийг 14564 гэснийг 15154 гэж өөрчлөх. Санал гаргасан Зулпхар гишүүн.

Зулпхар гишүүн тайлбараа хэлнэ үү.

**С.Зулпхар:** Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Би нөгөө шалгуур үзүүлэлтүүдийг үүнийг нь зүгээр нягталж үзсэн юм л даа. Салбартай холбоотой. Тэгээд нөгөө оруулж ирэхдээ жоохон зарим тоонуудыг нааш нь цааш нь болгочихсон, үндсэн нөгөө нэг зорилгоос нь хазайсан тоонуудаа тавьчихсан юм байгаа учраас одоогоос засаад явахгүй бол энэ чинь дараа нь хууль болоод батлагдчихаар зэрэг ахиад баахан асуудал үүсэх байх гэж бодож байгаа юм.

Тэгэхээр зэрэг 31.4.1 дээр байж байгаа тэр шалгуур үзүүлэлт бол хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ арга хэмжээнд хамрагдсан иргэдээс 3 ба түүнээс дээш сарын хугацаанд НДШ төлсөн иргэн биш эд нар бол дандаа байнгын ажлын байранд зуруулагдчихсан хүмүүс юм. Тэгэхээр энэ байдлаар нь томъёолж бичээд, тоог нь бол би нягталсан чинь энэ өмнөх тоо нь бол 14000, суурь тоо нь 14564 юм билээ. Тэгээд үүнийгээ бол жил болгоны тооцооллын хэлбэр байдаг. Түүгээр нь нэмээд тооцоолохоор 15154 болж байна лээ. Тэгээд үүгээр нь нэмж оруулсан нь зөв байх гэсэн ийм зарчмын зөрөөтэй санал оруулж байна. Тоо янзалж байгаа шүү гэж байна.

**Л.Энхнасан:** Тэгэхээр энэ нөгөө юу тоонуудыг л өөрчилж байгаа юм байна, тийм ээ? Шалгуур тоо, зорилго түвшнийг 14564-ийг 15154 гэж өөрчлөх тийм ээ. Тэгээд түүнийг дэмжихээр санал хураалт.

37,5-аар дэмжигдсэнгүй.

Энэ ер нь тоонуудаа Зулпхар гишүүн өөрөө сайн тайлбарлаж өгнө өө. Энэ дараачийн саналын томъёоллоор төслийн 31.4.4.2-ын шалгуур үзүүлэлт хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдаж ажилтай болсон хүнсний тусламж, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг иргэд гэснийг Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо гэж, суурь түвшнийг “35281” гэснийг “172967” гэж, 2025 оны зорилго түвшнийг “35633” гэснийг “183778” гэж өөрчлөх. Санал гаргасан Зулпхар гишүүн тайлбарлана уу?

**С.Зулпхар:** Энэ бүр 2 өөр зүйлийг хольчихсон байна лээ. Бид өмнөх төсвүүд дээр харахаар зэрэг энэ ер нь улсын хэмжээнд жилдээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамтын үйл ажиллагаанд хамрагдсан хүнийхээ тоог тавьдаг байхгүй юу. Тэгсэн чинь энэ хүнсний эрхийн бичигт хамрагдсан, тэгэхдээ

хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамарсан энэ иргэдийнхээ тоог тавьчихсан юм байна лээ. Тэгээд бид урьд нь авч явж байсан тоо суурь болон тооцоолол байдаг юм. Түүгээр нь би яамныхнаар шалгуулсан л даа. Тэгээд ирэхээр зэрэг энэ бол нийтдээ бол 172963 хүн суурь үзүүлэлтээр байж байгаа юм.

Тэгэхээр 25 онд бол энэ зорилтот түвшнийг бид нэмээд 183778 болгож байх ийм тооцоолол гарч байгаа юм. Өөрөөр хэлбэл бид чинь одоо 6 аймагт бол жоб центр нээчихсэн, ахиад бусад аймгуудад нээж байгаа байхгүй юу. Тэгэхээр хөдөлмөр эрхлэлтийн түвшин хүссэн, хүсээгүй нэмэгдэнэ. Бусад төслүүдээ дагаад.

Тэгэхээр энэ тоог зөв тавихгүй бол дараа нь улсын хэмжээний төлөвлөгөөг бид хэлэлцэх үед бол буруу, алдаатай тоо орж ирэх гээд байна. Би үүнийг яамныхнаас өөрөөс нь тодруулж асууж байж тавьсан тоо шүү.

**Л.Энхнасан:** Яам бол энэ дэмжиж байгаа юм уу, тийм ээ, Энх-Амгалан сайд тодруулга хийнэ үү.

**Л.Энх-Амгалан:** Гишүүд ээ, энэ ийм юм байгаа юм шүү. Нөгөө төсвийн тоо ямар нэгэн тоо хөдлөөгүй, төсөв дагасан нөгөө суурь үзүүлэлт, шалгуур үзүүлэлтүүд гээд нэг хавсралт орж ирдэг шүү дээ. Салбар салбарын нөгөө нэг хүрэх түвшин, хавсралт гээд. Түүн дээр бид нар хүрэх түвшнүүдээ их зөв гаргаж байж, суурь үзүүлэлтүүдээ зөв гаргаж хүрэх түвшнээ их зөв гаргахгүй бол энэ дээр ийм логикийн алдаанууд гаргачихсан учраас түүнийг л засаж байгаа тийм залруулгууд юм байгаа юм шүү.

Энэ чинь хэд хэдэн үзүүлэлтүүд байна уу, тийм ээ.

**Л.Энхнасан:** Тийм. Тэгэхээр энэ дээрээ гишүүд анхаараарай. Энэ нөгөө тоонууд нь нэлээн ийм зөрөөтэй буруу гарсан байгаа юм байна, тийм ээ. Яамны сайд бол өөрөө саналыг нь дэмжиж байгаа юм байна.

Ингээд саяын томьёоллоор санал хураалт. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт хийе.

Санал дэмжигдлээ. 62,5 хувиар.

Дараачийн 3 дахь санал. Зулпхар гишүүн бас гаргасан. Төслийн 31.5.3.2-ын суурь түвшин “36” гэснийг “16,7” гэж, 2025 оны зорилтот түвшнийг “40” гэснийг “20” гэж өөрчлөх.

Тайлбар хэлнэ үү. Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөр эрхлэх насны хүн амын тоо бол нэг 91700 байгаа юм. Тэгээд 23 оны шалгуур үзүүлэлт бол уг нь 16,7 байсныг 36 гээд алдчихсан байна лээ. Ийм өндөр хувь бол байхгүй, одоо. Тэгээд ийм өндөр хувь тавьчихаад дараагийн жил нь 40 хувь болгоно гэхчихсэн болохоор зэрэг ерөөсөө бүтэхгүй ийм шалгуур үзүүлэлт энэ андуураад л тавьчихсан юм шиг байгаа юм. Тэгэхээр үүнийг бол суурь түвшин нь угаасаа 23 оных чинь 16,7 байдаг. Би статистикийг нь шалгуулсан л даа, байгаа учраас бид энэ тооцооллын юу нь томьёололтой боддог юм, томьёотой юм. Тэр томьёогоор нь бодоод үзэхээр зэрэг

ирэх жилийн төсөвтэйгөө уялдсан байдлаар энэ бол 20 хувьд хүрэх юм байна гэдэг ийм төсөөлөл байгаа юм.

Тэгэхээр хэдүүлээ бодитой тоо тавихгүйгээр дараа нь Улсын Их Хурлаас ийм хууль батлаад өгчихдөг. Тэгээд түүнийхээ хэрэгжилтийг бид бол рационал бус байдлаар шаардаад сууж байх ийм л юм болох гээд байгаа учраас энэ тоог бол засмаар байна.

**Л.Энхнасан:** Дэмжье гэсэн “36”-г “16,7” гэж, “40”-ийг “20” гэж өөрчлөх. Дэмжих томъёогоор санал хураалт хийе.

62,5 хувиар дэмжигдлээ.

Үүрийнтуяа гишүүн дэмжсэнээр тэмдэглэх нь үү.

Бичээдэх үү? Жоохон хүлээгээдэхье.

Зулпхар гишүүн бүр яамны ажлыг аягүй сайн хийж байна.

Төслийн 31.5.1.1-ийн 2025 оны зорилго түвшнийг “5” гэснийг “3” гэж өөрчлөх. Тайлбар хэлнэ үү? Зулпхар гишүүн.

**С.Зулпхар:** Энэ Ай Си Эфийн олон улсын энэ үнэлгээгээр бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн түвшнийг үнэлэх энэ шинэ алхам руу орж байгаа юм. Ерөөсөө хийж чаддаггүй байсан. Тэгээд үүнийг бол яах вэ, олон улсын зөвлөхүүдтэй бид ярьж байх үед бол ер нь эхэлсэн жилээсээ бол нэг 3 хувиар бол эхний удаа хийж болно гээд. Тэр нь бол багцаагаар нэг 3300 хүн юм. Тэгсэн манай яамныхан бол нэг 5 хувь гээд их өндөр оруулаад ирчихсэн байна лээ л дээ. Тэгээд би олон улсын зөвлөхтэй нь ахиад уулзалдаж санал асуусан л даа. Тэгсэн энэ 3 хувиа барь аа, маш тодорхой жишээ нь чадавх байгаа цаана нь. Тэгэхээр зэрэг үүгээр нь оруулсан нь зөв гэж байгаа юм. Ай си эф гэсэн нэг ийм үнэлгээ юм уу. Энэ 5 хувь нь бол 4600 юм, үндэсний хэмжээний. 3 хувь нь бол 3300 юм. Тэгэхээр үүнийг ингэж оруулж ирж байна гэж байгаа юм. Өөрчлөлтийг.

**Л.Энхнасан:** Яам дэмжиж байгаа юм уу? Санал хураалт дэмжье гэсэн томъёоллоор.

56,3-аар дэмжлээ.

Зулпхар гишүүн дэмжсэнээр тэмдэглэе.

Дараачийн санал. Төслийн 31.5.2.1-ийн суурь түвшнийг “9386” гэснийг “1126” гэж, 2025 оны зорилго түвшнийг “10500” гэснийг “1200” гэж тус тус өөрчлөх. Зулпхар гишүүн тайлбар хэлнэ үү? Яам бол дэмжиж байгаа юм байна.

**С.Зулпхар:** Ахиад тоо янзалж байгаа шүү. Ямар нэгэн байдлаар зорилтыг бол, зорилтоос бол хазайгаагүй. Тэгээд энэ дээр яах вэ, би тоог нь нэмж оруулах ёстой гэж үзэж байгаа юм. 9386 гэсэн тоо байгаа юм. Өнгөрсөн жилүүдийн статистик бол мэргэжлийн сургалтын байгууллагад нэг 638, их, дээд сургууль, коллежид 488 гээд нийтдээ 1126 жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй суралцаж байгаа юм. 25 онд бол нэг 10500 хүрэх ийм боломжтой юм байгаа юм. Тэгэхээр

үүнийг бол 1200-гаар нэмээд ингээд 10500 гэж оруулж өгье өө гэсэн ийм зорилготой байна. Энэ угаасаа одоо хэрэгжүүлэх бэлтгэлтэй бол уялдсан ийм тоо байгаа шүү гэж байна. Тоог нь нэмж байгаа юм.

**Л.Энхнасан:** Нэмж байгаа гэж байна. “10500” гэснийг “1200” гэж байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт хийе.

56,3 хувиар дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрөөтэй санал. Зулпхар гишүүн. Төслийн 31.5.1.2-т 2025 оны зорилтот түвшнийг “16” гэснийг “12” гэж өөрчлөх. Энд тайлбар хэлээд хэрэггүй биз дээ тийм ээ. Шууд үүгээр нийт томъёоллоор санал хураалт хийе.

56,3 хувиар дэмжигдлээ.

Сайдын буруу хийсэн юмыг бид нар Байнгын хороо дээр засаж байна шүү.

Төслийн 2 дугаар. Одоо Эрдэнэбат, Саранчулуун, Бейсен, Нарантуяа-Нара, Сарнай гишүүдээс ирсэн зарчмын зөрөөтэй санал байна.

Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний 2025 онд дуусгахаас бусад хөрөнгө оруулалтын санхүүжүүлэх дүнг 40 тэрбум төгрөгөөр бууруулж, Эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгалын санд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдсэнтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхээр тусгах, зохицуулалт хийх гэсэн санал байна.

Эрдэнэбат гишүүн үгээ хэлнэ үү, тайлбар хийнэ үү.

**С.Эрдэнэбат:** 25 онд ерөнхийдөө дуусах шилжих зардлуудаас бусад хөрөнгө оруулалтаас яах вэ, жигд хасъя гэдэг байдал оруулж ирэхгүй бол би хаанаас нь гэж үүнийг нэгээс нь болгох вэ? Уул нь ажлын хэсэг дээр болон Сангийн яамтай ярьсан юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 4 сарын 1-нээс нэмэгдэж байгаа. Энэ бол хууль. Үүнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын санд нэг 20 орчим тэрбум нь шилжиж орох юм байна лээ. Төрөөс даадаг иргэд. Мөн бусад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс уячихсан байж байгаа зарим нэгэн зардлууд бол төрөөс хариуцдаг зардлууд нь бол тухайн тухайн зардалдаа шилжиж орох ёстой.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор шаардагдах зардлыг нь хөрөнгө оруулалтын зардал болон урсгал зардал гэдгийг нэмсэн байгаа шүү. Ер нь бол, урсгал зардлууд. Гэхдээ үүнийг би ажлын хэсэг дээр бол Сангийн яамтай ярьж байгаад сан хооронд нь шилжүүлэх байдлаар зохицуулж шийдэж болно гэдэг байдлаар уул нь ярьсан юм. Нэг сангаас өм цөм авах биш олон одоо, тухайлбал Эрүүл мэндийн даатгалын сан гэхэд эрүүл мэндийн сан дээр гэхэд бол тэртээ тэргүй үүнийг шийдсэн тохиолдолд 20 тэрбум нь ахмад, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөөс хариуцдаг Эрүүл мэндийн даатгалын сангаа сангийнх нь шугамаар бол шилжээд орно гэсэн үг.

Тийм учраас ийм зардлуудыг хасах байдлаар бол энэ хөдөлмөрийн хөлснийхөө доод хэмжээ буюу суурь цалингаа нэмсэн энэ шийдвэрээ төр нь өөрөө хариуцах эсэхээ төсөвтөө суулгаад нийтдээ нэг 40 орчим тэрбум төгрөг л гэдэг

байдлаар урьдчилсан байдлаар бол тооцоо гарч байгаа юм байна лээ. Ихэнх нь бол төсвийн төсөв дотроо сан, төсвөөс сан дотроо шилжих ийм зардлууд байгаа учраас үүнийг тусгаж өгөөч гэдэг ийм саналыг оруулж байгаа юм.

**Л.Энхнасан:** Үүнийг Сангийн яамнаас Санжаадорж маань хаашаа орчхов. Тийм, энэ ажлын хэсэг дээр илүү ярих хэрэгтэй байна шүү. Яагаад гэвэл энэ чинь яг хаанаас бууруулах вэ гэдэг нь тодорхойгүй юм байна.

Сайд, харин тийм. Түүнийгээ яг тодорхой байхгүй бол энэ чинь ингээд бид нар дэмжээд явчихвал нэг өөр газраас, бас л нэг хамааралтай газраас хасчихвал яах вэ. Нэг зарчмаа уул нь бариад явбал зүгээр байх. Эрдэнэбат гишүүн.

**С.Эрдэнэбат:** Өмнө яах вэ, бид нар нэг тэгж үзэж байсан юм. Нийт төсөв хөрөнгүүдээс хасаад гээд нэг эрүүл мэндийн сан дээр нэмье гээд нэг зарчмын санал Ганмаа гишүүн гарч байсан санаад байна. Сая Үүрийнтуяа гишүүний хэлдэг ч гэсэн нэг юмыг шууд барьж аваад тавьчих гэхээр энэ санал нь өөрөө уначих магадлалтай. Тийм учраас үүнийг бол уул нь заавал гишүүдээр тоо бодуулаад байх биш. Сангийн яам, ажлын хэсгийнхэн бол уг нь гаргаж гарцыг нь шийдэж өгөх ёстой гэдэг, би тэгж орж ирж байгаа болов уу гэдэг байдлаар уг нь бодсон.

Тийм учраас үүнийг бол хураалгаад, тэгээд саналынх нь тэр зардлуудыг нь ажлын хэсэг, Сангийн яам өөрсдөө аль нэгэн зардал дээр хүндрэл учруулахгүй байдлаар оруулаад ирвэл уул нь би болох юм. Тийм ч учраас 25 онд бол шилжих байдлаар хасахгүй гэж байгаа зарчмыг нь хүндэтгээд түүнийг бол хасахгүй, 25 онд дуусах юмнуудыг нь. 26, 27, 28 энэ тэр гээд явж байгаа зардлуудаас нь бага багыг хасаад шийдчих байдлаар явбал болох байлгүй. Тэр зардлуудыг нь дараа нь төсвийн зохицуулалт хийх байдлаар бол боломж байгаа болов уу л гэж бодож байна.

**Л.Энхнасан:** Салбарын сайд Энх-Амгалан сайд. Яах вэ, энэ чинь манай Байнгын хороо бол энд дэмжээд явахад бол асуудалгүй байх л даа. Тэгээд нөгөө хаанаасаа юунаас аль төсөл, арга хэмжээнээс хасах билээ гэдэг ч юм уу.

Энэ Сангийн яамнаас хариулах хүн байна уу? 2 дугаар микрофон. Хэн хариулах гэж байна? 2 дугаар микрофон уу тийм ээ. Ажлын хэсэг.

Сангийн яам Хууль, эрх зүйн газар Энхболд. Энэ нэг талаас нэмэх гэж байгаа бол нөгөө тал тодорхой ямар эх үүсвэрээс нэмэх гэж байгаа вэ гэдгийг тодорхой хэлэхгүй бол дэгийн хууль зөрчигдөж болзошгүй байна. Яг хариуцсан улсууд нь энэ давхар давхар Байнгын хороонууд яваад байгаа учраас тэнд дуудагдаад хариулт, асуулт хариултад хариулж байгаа.

**Л.Энхнасан:** Яг тодорхойгүй учраас ажлын хэсэгтээ. Яах вэ, бид нар бол яах вэ, хураагаад явчихна. Эх үүсвэр нь мэдэгдэхгүй байгаа. Тэгээд дараа нь дэгээ зөрчсөн болно шүү дээ, тийм ээ.

Ажлын хэсэг рүү бичиг явуулчихъя, тэгэх үү. Энэ тэгэхгүй бол яг хаанаас хасагдах нь тодорхойгүй болохоор бид нар дараа нь дэгээ зөрчсөн асуудалд орно, тийм ээ. Тийм, Сангийн яамнаас яг тодорхой хариулах хүн байхгүй учраас энэ дээр. Мэдээж бид нар бол Байнгын хороогоороо үүнийг дэмжихэд бол бэлэн байгаа шүү дээ. Тэгэхдээ яг.



Гишүүд ээ, нөгөө төслөө дагасан нөгөө хуулийн дараачийн асуудал байгаа шүү дээ. Тийм.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа Төсвийн байнгын хорооны хуралд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

14.38 цаг

**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэж эхэлье.**

Засгийн газраар 2024 оны 12 сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ бол Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

*Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхдугаар хэлэлцүүлгийг хийе.*

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсэг хэвээрээ юу, тийм.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Эрдэнэбат гишүүнээр тасалъя.

**С.Эрдэнэбат:** Энэ ажлын хэсэг, Сангийн яамныхан энэ Байнгын хороон дээр хүндэтгэлтэй хандаад, байж байх хэрэгтэй байна шүү дээ. Яах гэж тэгвэл ажлын хэсэг гарсан юм. Тэгээд гишүүдээр тоо бодуулах гээд, томъёо бодуулах гээд ингээд байх юм бол ажлын хэсэг, Сангийн яам гэж байх ямар хэрэг байдаг юм. Энэ чинь хуульд байж байгаа гол нь чухал заалт. Тийм учраас энэ тал дээр бол Байнгын хорооны дарга энэ тал дээр анхаарч өгөөрэй. Саяын тэр санал бол зарчмын зөрөөтэй саналын хувьд бол уул нь хураачих хэрэгтэй байсан юм. Олон удаа яригдсан асуудал. Чуулган дээр дахин дахин яриад байх жоохон төвөгтэй.

Хэмнэлтийн хуультай холбоотой зүйлийг хэлэхэд бас л ялгаа байхгүй. Яах вэ, тэр янз бүрийн хэмнэлт хуульд байхгүй хэт хэтрүүлсэн тэр шагнал урамшуулал гээд тийм зүйлүүдийг хэмнэлтийн хууль бол тодорхой хэмжээгээр байх нь бол зөв. Гэхдээ ковидын үеийн нөхцөл байдлаас үнэлээд хуульд байж байгаа маш олон зүйлүүдийг хэмнэнэ гэдэг байдлаар оруулаад ирэхээр эргээд үүнийг гаргахын тулд, зайлшгүй гаргах ёстой зардлуудыг гаргахын тулд нөгөө хүмүүс маань хууль зөрчиж, өөр байдлаар асуудалд хандах байдлаар бүр их төвөгтэй байдал руу оруулах асуудал бий, 1.

2 дугаарт, бид нар чинь өмнө нь бүх л асуудлуудыг шат шатан дээрээ шийд гэдэг ийм зарчмын юм тавьж ирсэн. Тухайн байгууллага нь үр ашиг гаргаад, хүмүүстээ тодорхой хэмжээний цалин хөлсний нэмэгдэл, урамшуулал, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх асуудлыг салбарын яамд нь, ААН байгууллагууд нь, шийд гэдэг байдлаар ийм хууль ч байгаа. Хөдөлмөрийн хуулиа ч тэгж өөрчилсөн. Тэгэнгүүт одоо яаж байна вэ гэхээр хэмнэлтийн хууль байгаа учраас хуульд байхгүй ямар ч зардал тавихгүй гэдэг байдлаар хууль яваад байгаа учраас зөрчил дагуулаад байгаа юм. Тэр нь явж явж хаана ирж шийдэгдэх гээд байна вэ гэхээр, буцаад л явж явж Засгийн газар дээрээ шийдэгдэнэ. Нэг байгууллагын нэг ажилтанд үр дүнтэй ажилласных нь төлөө урамшуулал олгох асуудлыг, эс үгүй бол сайд, эс үгүй бол төсөв захирагч. Тийм учраас ийм байдлаар бол нөгөө хэт нэг тал руу нь урвуулж шийдэхгүйгээр яг ямар, хэмнэлтийн тухай хуулийн ямар хэсгийг нь хасъя гэдэг байдлаар ямар үндэслэлээр оруулж ирж байгааг нь тодруулж асуумаар байна.

**Л.Энхнасан:** Санжаадорж дарга хариулна уу. 4 дүгээр микрофон.

Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр бол 3 заалттай орж ирсэн байгаа. 3 заалт нэмж орж ирж байгаа. Эхнийх нь бол Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур цалин хөлс, урамшуулал олгохыг хориглоно гээд. Өөрөөр хэлбэл цалингийн санд нь бүртгэж олгох энэ процессыг хийе гэж байгаа юм. Үндсэн цалинг нь. Түүнээс хуулиас гадуур бол дахиж тусад нь явахгүйгээр нөгөө зардлыг нь хэмнэх агуулга.

2 дахь нь, байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахыг хориглосон заалт дээр орж ирж байгаа. Тэгэхээр энэ спортоор холбоотой зардал бол гарахгүй болж байгаа гэсэн үг.

3 дахь нь, илүү зохион байгуулалттай холбоотой зардал бол хэмнэлтийн юун дээр нэмж орж ирж байгаа. Энэ нь бол юу вэ гэхээр сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг илүү цахимаар зохион байгуулах, цахимаар зохион байгуулж байгаатай холбоотойгоор шатахуун, түрээс, албан томилолтын зардлыг мөн хэмнэх гэсэн илүү тийм зохион байгуулалтын шинжтэй ийм зардал орж ирж байгаа. Тийм.

**Л.Энхнасан:** Би 1 дүгээр зүйл дээр зарчмын зөрөөтэй санал байгаа. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг “Үндэсний зөвлөл” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэхээр байгаа. Энэ яагаад гэвэл тийм, Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүд, үүнд: үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно гэхихсэн байгаа. Энэ нь болохоор Нийгмийн даатгалын ерөнхий хууль 35.16, 35.17, 35.19, 35.20, 35.21 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.6 дахь хэсгийг зөрчиж байна гэж үзэж байна.

Сайд бол энэ дээр дэмжиж байгаа, тийм ээ. Энэ саналыг дэмжье гэсэн томъёогоор санал хураалт хийе.

Тэгвэл горимын санал гаргахгүй бол болохгүй байх. Энэ Эрдэнэбат гишүүн. Тийм, үүнийгээ. Эрдэнэбат гишүүний микрофоныг өгнө үү.

**С.Эрдэнэбат:** Төхөөрөмж дээр саатал гараад саяын саналын томьёолол дээр дэмжсэн санал өгсөн. Хүчингүй болгоод дахиж хурааж өгнө үү. Энэ тодруулаад хэлчих үү гишүүн ээ, нэгмөсөн. Хуульд байж байгаа Үндэсний зөвлөлүүдийн урамшуулал гэдэг дээр зөвхөн төрийн албан хаагч нар авдаг гэж ойлгож болохгүй. Янз бүрийн энд тэндхийн байгууллагуудаас орж ирж байгаа хүмүүсийг үнэгүй ажилла гэж хэлж байгаагаас өөр аргагүй. 2 дугаарт, хууль зөрччихдөг учраас энэ бол цөөхөн байдаг юм. Нэг гарын 5 хуруунд багтахаар Үндэсний зөвлөл байна уу даа, хуульд байгаа, тийм.

**Л.Энхнасан:** Тэгэхээр саяын санал хураалтыг нөгөө хүчингүй болгохыг санал хураалт хийе.

Дахиад уу. Бейсен гишүүн уншигдсан юм уу? 50-аар дэмжигдсэнгүй, дэмжигдсэнгүй.

2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? 2 дугаар зүйл нөгөө тогтоолын хэмнэлтийн тухай хуультай холбоотой.

Ганмаа гишүүн асуултаа асууна уу?

**Д.Ганмаа:** Сайн байцгаана уу? Энэ асуулт гэхээсээ илүү түрүүн би орж ирчхээд нөгөө энэ чинь бид нар маш хурдтай, маш олон хурал зэрэг яваад байгаа, тийм ээ. Чөлөө авч гараад, нөгөө Байнгын хороондоо саналаа хураалгачхаад буцаж хүрч ирэх хооронд эхний Эрүүл мэндийн сайдынхыг байх үед хийгдэх ёстой ажил байсан. Юутай холбоотой вэ гэхээр, шалгуур үзүүлэлттэй холбоотойг нь л би ярья. Асуултуудыг нь одоо больё. Яагаад гэхээр хэнээсээ асуух вэ, би энд тийм ээ. Энэ яалт т ч үгүй ярих, протоколд заавал үлдээмээр шалгуур үзүүлэлт байна. Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ аль алинтай нь холбоотой. Энэ шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлж чадахгүй болохоор бид нар ерөөсөө энэ хаашаа яваад байгаа, ямар зорилго зорилтод хүрэх гээд байгаа үүнийгээ яаж хэмжих юм. Тэр дотроо өөрөө хэрэгжилт нь хамт ч явж байх шиг, тийм ээ. Өмнөх Байнгын хороо дээр яг өмнөх төсвийн өмнө энэ шалгуур үзүүлэлтийн талаар нэлээн дэлгэрэнгүй ярьж хэлсэн. Яах вэ, жоохон засварууд хийжээ. Өнгө, өнгөн засварууд гэдэг юм уу, тийм ээ, бүр яг нарийн сайн засваруудаа хурдан хийж авмаар байна. Гүйцэтгэл дээр ч гэсэн үүнийг бид нар ярина шүү дээ.

Үүнийг тэгэхээр бүр нарийн бичсэн байдлаар протокол болгоод, сайдад салбарын яамныханд хүргүүлмээр байна. Жишээлбэл хэд хэдэн юм ярих вэ. Энд товчхон хэлье. Одоо жишээлбэл сая хэлсэн, шалгуур үзүүлэлтийг нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ гэж хуваах нь ерөөсөө их учир дутагдалтай. Ингэж хаана ч бусад улс оронд ингэдэггүй юм. Хамтад нь 1 дүгээрт явъя.

2 дугаарт, нийгмийн эрүүл мэнд гэдэг нь ингээд маш товчоор бол нийт хүн амын эрүүл мэндийн тухай асуудлыг яриад байгаа байхгүй юу. Тэд нарыг хамгаалах, сайжруулах гол зорилгыг агуулсан. Тэгэхээр эрүүл мэндийн тогтолцооны эцсийн зорилгыг хангахад чиглэсэн үр дүнгийн хэмжээнүүдийг бид нар хэмжиж үзэх ёстой байхгүй юу. Тэгж байж энэ чинь ки пи ай болж өгч байгаа юм.

Тэгэхээр чинь жишээлбэл бид нарын тийм ээ, дундаж наслалтыг хэдэн хувиар нэмэгдүүлэх юм, яаж өвчлөлөөс сэргийлэх юм, нас баралтыг хэдэн хувиар бууруулах юм, эх нярайн эндэгдлийг хэдэн хувиар багасгах юм, эрүүл мэндийн нийт зардал нь хувь хүний төлж байгаа төлбөрийн хэмжээг яаж бууруулж байгаа юм. Газар зүйн байршлаас хамаараад тусламж үйлчилгээний хүртээмж, орлогоос хамаараад тусламж, үйлчилгээний эрүүл мэндийн хүртээмж, тэгээд ч одоо чанар, иргэдийн сэтгэл ханамжийн хувь. Эдгээрийг бүгдийг нь яг талс бүрээр нь хувьтай нь тэгээд урт удаан хугацаа, дундын хугацаатайгаа уялдуулж хиймээр байгаа байхгүй юу. Бүр нэршлээр нь саяын нэр бүрээр нь оруулмаар байна. Ки Пи Ай дотроо.

2 дугаарт, яг эмнэлэг тусламж буюу эмнэлгийн тусламж үйлчилгээ дээр болохоор эрүүл мэндийн тогтолцооны ийм эцсийн зорилгыг хангахад чиглэсэн тийм завсрын зорилтуудыг заавал үр дүнд нь шалгуур үзүүлэлттэй нь ингээд хамт шигтгэж оруулмаар байна. Жишээлбэл, эмнэлгээс шалтгаалсан халдварын хувь, эмнэлгийн алдааны хувь, цусны даралт ихсэх, эрт илрүүлэг хувь гээд явчихсан байгаа. Тэгэхээр ... /минут дуусав/

**Л.Энхнасан:** Юу тоот явуулчихъя, тийм ээ. Одоо энд нөгөө сайдад би чөлөө өгсөн бусад ЭМЯ-ны энэ ажлын хэсгийн хүмүүсийг бол яв гэж хэлээгүй байгаа, энд байхгүй байна. Хариулт өгөх хүн алга. Тэгэхээр тоот явуулсан нь зүйтэй байх.

2 дугаар зүйлд асуулт асууж дууслаа.

3 дугаар зүйлд зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? 2 дугаар зүйлд. алга байна.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нарантуяа-Нара гишүүн.

**М.Нарантуяа-Нара:** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдаасаа асууна. Энэ 25 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 6 дугаар зүйл дээр энэ нийгмийн халамжид хамрагдах шалгуурыг оновчтой болгох, хөнгөлөлт үйлчилгээний давхардлыг арилгах, халамжаас хөдөлмөр хөдөлмөрт шилжих, хөдөлмөр хөтөлбөр хэрэгжүүлэхээр зэргээр нийгмийн халамжийн сангийн зардлыг 1,3 хувиар бууруулах гээд заачихсан байна л даа. Тэгээд энэ ер нь бол хөдөлмөр хөдөлмөрөөс, халамжаас хөдөлмөрт шилжих хөтөлбөрийг бол маш сайн дэмжиж байгаа. Гэхдээ энэ дээр яг ямар ямар халамжийн хөтөлбөрүүдийг танаад 1,3 хувиар бууруулсан бэ? Энэ танасан хөтөлбөрт чинь хүүхэд, ахмад настны энэ халамжийн зүйл багтсан байгаа юу? Энэ тал дээр нэг мэдэх хүсэлтэй байна.

**Л.Энхнасан:** Энэ Засгийн газрын чиглэл өгөх нөгөө тогтоол дээр асууж байна. Тэгэхдээ сайд хариулаад өгнө өө. Энх-Амгалан сайд хариулна уу?

**Л.Энх-Амгалан:** Бид нар нэг ийм юм яриад байгаа шүү дээ, Нараа сайд аа. Одоо ингээд нэг халамжийн нэрийн доор халамж хавтгайрсан гэдэг нэг ойлголт нийгэмд ингээд төрчихсэн байгаа. Тэгээд төсвөөс халамжийг зарцуулж байгаа зардал чинь бараг өнгөрсөн оны гүйцэтгэлээр бол 2,2 их наяд, одоогийн 25 оныхоор 2,6 их наяд болчихоод байгаа. 2,6 их наядыг чинь бараг 1,8 их наяд, 1,7 их наяд чинь хүүхдийн мөнгө болчихоод байгаа шүү дээ. Хүүхдийн мөнгө. Тэгээд нөгөө

ерөөсөө хүүхдийн мөнгө, одонтой ээж, насны хишиг, нөгөө цалинтай ээж гээд ингээд бүх нөгөө хэрэгжүүлсэн нийгмийн хөтөлбөрүүдээ дандаа халамжийн хуулиар халамж гэдэг нэрийн дор халамжийн хуулиар ингээд хэрэгжүүлээд байгаа учраас бол энэ тоо нэлээн их өндөр харагдаж байна.

Тийм учраас бид нар удахгүй Улсын Их Хурал дээр энэ халамжийн тухай хуулиа шинэчилж, концепцын хувьд шинэчилж өргөн барья аа. Аль нь хүн амаа өсгөх бодлого юм бэ, тийм ээ. Аль нь гэр бүлээ дэмжих бодлого юм бэ гэдэг энэ хөтөлбөрүүд дээр бид нар бүгд бодлогын шинжилгээнүүд хийгдээд, та бүхэнд танилцуулсан. Байнгын хорооныхоо гишүүдэд танилцуулсан. Энэ хүрээндээ бол бид нар ер нь 25 ондоо энэ өнгөрчихсөн зарим үр дүн муутай байгаа хөтөлбөрүүдээ заримыг нь хугацаатайгаар хугацаа тавих. Тийм ээ, хэн нь яг нөгөө хүнсний талон авч байгаа, хөдөлмөрийн чадвартай мөртөө хүнсний талон авч байгаа иргэд дээр бид нар ямар хугацаа өгөх юм гэх мэтчилэнгээр бодлогын шинэчлэл хийх гэж байгаа. Нэг ийм зорилтууд тавьж байгаа учраас бид нар нэг юуны нийгмийн халамжийн зардлыг нь 1,2 буюу 31 тэрбумаар танаж ийм бодлогууд хийе л гэсэн ийм зорилтууд, одоо бид нар үүрэг авч байна гэсэн үг шүү дээ. Засгийн газар үүрэг авч байна гэсэн үг, энэ хүрээнд. Түүнээс биш энэ дээр халамжийн тэтгэвэр, хүүхдийн мөнгө, асаргааны тэтгэмж, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжээс 1 ч төгрөг хасагдаагүй. Тийм.

**Л.Энхнасан:** Зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна.

4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу? 1 зарчмын зөрөөтэй санал байна. Үүрийнтуяа гишүүнээс гарсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дараах зарчмын зөрөөтэй санал гаргаж байна. Уг хуулийн төслийн 4 дүгээр зүйлд энэ хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө гэж заалтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж өөрчлөх. Үндэслэл нь бол 2025 оны төсвийг хэрэгжилттэй холбоотой хуулийн өөрчлөлт орсон байгаа.

Энэ тайлбар тавих уу. Үүрийнтуяа гишүүн тайлбараа хэлнэ үү.

**Д.Үүрийнтуяа:** Энэ зарчмын зөрөөтэй саналыг би өмнө нь Аж үйлдвэржилтийн байнгын хороон дээр хураалгаад дэмжигдсэн. Яагаад ингэж оруулж байгаа юм бэ гэхээр бусад хуулиуд дээр бол хэрэгжих хугацааг нь 25 оны 01 сарын 01-нээс гэж байгаа юм. Төрийн хэмнэлтийн хуулийг хууль батлагдсан өдрөөс гэхихсэн байгаа юм. Тэгэхээр магадгүй бид нар 12 сарын 15-ны дотор 15-нд хуулиа баталчихлаа гэхэд энэ хууль 12 сарын 15-наас эхлээд хэрэгжих болчихоод байгаа байхгүй юу. Гэтэл энэ чинь 25 оны төсөвтэй холбоотойгоор л өөрчилж байгаа заалтууд шүү дээ.

Тийм учраас төсвөө дагаж, 25 оны 1 сарын 1-нээс явах ёстой. Хэрвээ бид нар энэ хууль батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр гээд үзчих юм бол дараа нь хяналт шалгалтын төрийн аудитын байгууллага ч юм уу, төсөвт байгууллагад шалгалт хийхэд 15 хоногийн хугацаанд санхүүгийн зөрчил үүссэн ийм асуудлууд

үүсэх үүсэх гээд байгаа юм. Тийм учраас үүний хэрэгжилтийг ирэх оны 01 сарын 01-нээс төсвөө дагаж явах нь зүйтэй гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан.

**Л.Энхнасан:** Дэмжье гэсэн нэр томъёоллоор санал хураалт явъя.

56,3 хувиар дэмжигдлээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг анхны хэлэлцүүлгээ хийж дууслаа.

*Одоо Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийе.*

Тогтоолтой холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрөөтэй санал байна уу? Үүрийнтуяа гишүүн.

Үүний дараачийнх дээр байгаа шүү дээ, тийм ээ. Харин тийм. Одоо гарч болохгүй шүү. Та бүгд бүгдээрээ хурдан хурдан.

Зарчмын зөрөөтэй саналаа.

**Д.Үүрийнтуяа:** Засгийн газарт чиглүүлэх тухай

**Л.Энхнасан:** Хүлээж байгаарай. Нөгөө түрүүн хуулийн төслийг нөгөө анхны хэлэлцүүлгийг хэлэлцүүлээд дууслаа гэх.

Зарчмын зөрөөтэй саналыг. Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төслийн 3 дахь заалт. Улсын төсвийн хөрөнгөөр өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдэж байгаа барилга байгууламжийн төсөвт магадлал хийх, аудитын дүгнэлт гаргуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, 25 оны 1 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн танилцуулах гэж байгаа юм. Энэ бол зөвхөн энэ 25 оны төсөв дээр орох асуудлыг тодруулж, танилцуулах асуудал яваад байна гэж ойлгож байгаа. Өмнөх цаг хугацаанд хийгдээд одоо төсөв дээр ачаалал болоод үргэлжлээд яваад байгаа асуудлыг засаг өөрөө үүнийгээ судалж, тэр эрх олгож байгаа холбогдох сайд нар нь, тэр эрх олгож байгаа, зөвшөөрөл олгож байгаа хөгжлийн төвүүдийнхээ үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, ямар нэмэлтүүд үндэслэлгүй нэмэгдчихээд байгаа юм бэ гэдгээ өөрсдөө танилцуулах хэрэгтэй байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг нэмж тусгамаар байна. Барилга хөгжлийн төв, Зам тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төвийн хийсэн магадлалыг харьяалах сайд нар нягтлан шалгаж, өмнөх жилүүдэд хийгдсэн төсөв дээр ямар хэмжээний төсвийн нэмэлт ачаалал үүссэнийг тогтоон Улсын Их Хуралд танилцуулах гэдэг томъёоллыг нэмж оруулахыг хүсэж байна.

**Л.Энхнасан:** Энэ дээр Сангийн яам Санжаадорж дарга хариулна уу? 4 дүгээр микрофон. 5 дугаар микрофон, 3 дугаар микрофон.

Сангийн Яам Санжаадорж. Сангийн яамны зүгээс яг энэ дээр бол тайлбар хийх зүйл байхгүй, нэмж оруулахад бол тэгээд татгалзах зүйлгүй.

**Л.Энхнасан:** Зарчмын зөрөөтэй санал байгаа юм уу, бичээд өгөх юм уу? Бичээд өгчих. Дараа нь санал хураалтаа хийчихье.

Дараа санал хураалт хийчих үү. Дараачийн асуудал руу явж байх уу, гишүүд ээ. Тийм.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газарт чиглэл өгөх Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дууслаа.

*Одоо “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгээ эхэлье.*

Асуулт асуух гишүүд байна уу? Дахиад 1 төсөл байгаа, тийм. Байхгүй байна.

Зарчмын зөрөөтэй санал байна уу? 2 санал байна.

1.6. Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох гэсэн санал байна. Саналыг гаргасан Зулпхар, Саранчулуун, Идэрбат, Чинбүрэн гишүүн. Хэн хариулах вэ? Тайлбарлах уу? Зулпхар гишүүн тайлбар хийнэ үү.

**С.Зулпхар:** Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар өнгөрсөн 4 жилд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт техник, тоног төхөөрөмжийн хангалт бол үндсэндээ хийгдээгүй. Яг энэ хугацаанд энэ салбар өөрөө нэг 6000 гаруй албан хаагчтай. Түүнээс гадна үндсэндээ 3,4 сая хүнд үйлчилгээ үзүүлдэг ийм л салбар л даа. Энэ хугацаанд цахим шилжилттэй уялдсан байдлаар нийгмийн даатгалын үйлчилгээ 36 үйлчилгээний үндсэн 30 орчим нь бол үндсэндээ нийт үйлчилгээний хамрагдалт бол 90 хувь цахим шилжилтэд хийгдчихсэн, их сайн болсон.

Халамжтай холбоотой, хүүхэд хамгаалалттай холбоотой шилжилтүүд хийгдэж байгаа. Тэгээд бид энэ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахтай холбоотой зарим техник хэрэгслийн хангалтыг хийх зайлшгүй шаардлагатай юм байгаа юм. Боловсролын яаманд бид сургуулийн чанар, хүртээмжийг сургалтын чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээс ийм арга хэмжээ авсан.

Тийм учраас энэ бол үндсэндээ цаанаа бол 21 аймаг, 9 дүүрэг, 330 сум, 1500 орчим багт л үйлчилгээ үзүүлж байгаа учраас энэ чиглэлийн эрхийг бол сайд нь нэмээд өгчихвөл. Гэхдээ энэ төсөвт бол өөрчлөлт орохгүй. Тэгээд ийм байдлаар бид энэ асуудлыг шийдэх учиртай. Энэтэй уялдсан байдлаар хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ ч тэр, нийгмийн хамгааллын үүн дотроо нийгмийн даатгалын болон халамжийн, хүүхэд хамгааллын үйлчилгээнүүдийн чанар

хүртээмж бол сайжирна гэсэн ийм зорилтын үүднээс энэ зарчмын зөрөөтэй саналыг оруулж байна. Дэмжиж та бүхэн саналаа өгнө үү.

**Л.Энхнасан:** Сайд, сайд ямар санаатай байгаа юм. Дэмжье. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

Үүрийнтуяа горимын санал гаргахгүй бол болохгүй шүү. Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Төхөөрөмжид саналаа уншуулах гэсэн боловч уншуулж чадсангүй, хүлээж авсангүй. Тийм учраас протоколд дэмжсэнээр оруулж өгөхийг хүсье.

**Л.Энхнасан:** Бейсен гишүүн дэмжсэнээр үү, тийм ээ. Бейсен гишүүн, Үүрийнтуяа гишүүн дэмжсэнээр протоколд тусгаад. 16 юу билээ, хүчингүй болгож байж яахгүй бол болохгүй тийм ээ. Тэгэхээр хүчингүй болгоё гэсэн горимын санал. Дэмжье гэсэн томъёоллоор.

56,3 хувиар сая хүчингүй боллоо, тийм ээ.

Тэгэхээр дахиад үндсэн санал. Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын харьяа шинээр баригдаж хөрөнгө батлагдаагүй нэн шаардлага зарим газар байгууллагад, өө энэ чинь өөр юм байна шүү дээ. Түрүүн өөр юм уншигдчихлаа. Уучлаарай.

1.6. Гэр бүл, хөдөлмөр нийгэм хамгааллын салбарын харьяа газар, байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсийн зарчмаар хангах эрхийг төсвийн ерөнхийлөн захирагчид олгох гэсэн. Үүнийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт хийе.

86,6 хувиар дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрөөтэй санал.

Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын харьяа шинээр баригдаж, баригдах хөрөнгө батлагдаагүй, нэн шаардлагатай зарим газар, байгууллагад түрээсийн барилга ашиглаж, үйл ажиллагаа явуулах гэсэн санал байна. Саналыг Зулпхар, Саранчулуун, Идэрбат, Чинбүрэн гишүүд гаргажээ.

Тайлбар хийнэ үү.

**С.Зулпхар:** Энэ манай салбарт Ариунзаяа сайдыг байх үед бид “халамжаас хөдөлмөрт” гэсэн том уриа дэвшүүлээд, ер нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогодоо их онцгой анхаарч эхэлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, хөтөлбөрүүдийг бол ер нь шинэчилсэн л дээ. Зохих үр дүнгүүд ч гарсан. Энэ явцад бол зарим үр дүнгүүдийг сайтар туршаад, эндээс ер нь бол хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг бид нарийн болгох ёстой юм байна.

Түүнээс гадна иргэдэд ойртуулах ёстой юм гэсэн арга хэмжээнүүд авсан. Цахим шилжилтүүд ч хийгдсэн. Одоо ингээд бид нөгөө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлахдаа бол ер нь бид цаашдаа Жоб центр буюу олон улсын жишгээр иргэд рүү ойртсон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг



нэвтрүүлнэ гээд ингээд тодорхойлж байсан юм. Тэгээд энэтэй холбоотой мэдээж хэрэг бид барилга байшин бариад байж болохгүй. Үүнийг бол бид аль болох л хялбаршуулсан байдлаар олон улсын сайн жишгээр хийнэ гэдэг ийм чиглэл байх учиртай.

Тэгэхээр зэрэг энэ ажлыг бол зогсоож болохгүй. Ер нь би түрүүн нөгөө шалгуур үзүүлэлтээр ирэх жил бол 183 мянган хүнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйлчилгээ үзүүлэх ёстой. Одоо бидний тавьсан шалгуураар. Түүнээс гадна нэг 50 гаруй мянган хүний ажиллах хүчний хомсдол байгаа юм. Энэ хомсдолыг даван туулах учиртай. Энэтэй уялдсан байдлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас яамнаас уг бол 6 төв нээхээр бэлдчихсэн байгаа. Би тэр тоог нь бол авсан. Цаашдаа бол энэ 21 болж нэмэгдэх учиртай.

Тэгэхээр зэрэг үүнийг бид барилга байшин байгуулж чадахгүй учраас Засгийн газрын өөрийнх нь оруулж ирсэн үндсэн чиглэл байгаа шүү дээ. Бид зарим нэг үйл ажиллагааг бол түрээсний хэлбэрээр, төр, хувийн хэвшлийн түншлэлээр, төр, иргэний нийгмийн түншлэлээр хийдэг хэлбэр лүү орно гээд. Энэ саналыг бид Улсын Их Хурлын гишүүн Саранчулуун, Идэрбат, Ж.Чинбүрэн нар гаргасан юм байгаа юм. Ингээд энэ санал бол өөрөө онцгой ач холбогдолтой ийм санал учраас та бүхэн дэмжиж өгөөрэй. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар бид ядуурлыг бууруулах, халамжаас гарах ийм зорилт тавьж байгаа шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

**Л.Энхнасан:** Сангийн сайд, Сангийн сайд гэнэ. Харьяа Энх-Амгалан сайд бол дэмжиж байгаа, тийм ээ. Тэгвэл дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт хийе.

62,5 хувиар дэмжигдлээ.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгээ хийж дууслаа.

Монгол Улсын.

Нэг нөгөө Үүрийнтуяагийн юм байгаа шүү дээ. Үүрийнтуяагийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт хийе. Дэмжье.

Уншаадхаач, тийм ээ. Тэгэхгүй бол яг юугаа батлах ёстой. Үүрийнтуяа гишүүн.

**Д.Үүрийнтуяа:** Тогтоолын төслийн энэ “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоол. Энэ тогтоолын төслийн 1 дүгээр зүйлийн 3-д заасныг дараах байдлаар өөрчлөх саналтай байгаа юм.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх онуудад ажил нь эхэлсэн боловч төсөвт өртөг нэмэгдүүлж байгаа барилга байгууламжийн төсөвт өртгийг Барилга хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Эрчим хүчний үндэсний төвийн эрх бүхий төсөвчдийн хийж байгаа энэ үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нэмэгдсэн төсөвт өртгийн магадлалд дахин шалгалт хийж, дүнг Улсын Их

Хуралд танилцуулах гэдэг байдлаар томьёолж оруулж байгаа юм. Саналыг тэгээд энэ томьёоллоо би бас яг албан бичгээр, юу бичгээр гаргаад өгье

**Л.Энхнасан:** Тэгье. Дэмжье гэсэн санал хураалт хийе.

56,3 хувиар дэмжигдлээ. Баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газрын чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцүүлгүүдийг явуулсан талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болормаа Төсвийн байнгын хорооны хуралд танилцуулна.

15.12 цаг

Хурал дууссаныг мэдэгдье. Хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

Ажлын хэсэгт баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ